



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО**

**МАНДАЛГОВЬ ХОТ
2003 ОН**

ДУНДГОВЬ АЙМГИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Энэхүү аймгийн хэтийн хөгжлийн бодлого нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрт харьцаанд үндэслэн нийгмийн дэвшлийг хангах талаар баримтлах бодлого түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох ба 1997 онд боловсруулж батлуулсан "Аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр", "Аймаг хөгжүүлэх төсөл"-ийн тодотгосон хувилбар болох баримт бичиг юм.

Оршил

Дундговь аймаг 1942 онд байгуулагдсан, 7469,0 мянган га нутаг дэвсгэртэй, 1475,0 мянган толгой малтай, 51,3 мянган хүн амтай, засаг захиргааны нэгжээр 15 сум, 64 багтай.

Манай аймгийн нутаг дэвсгэрийн хойд хэсэг хуурай хээрийн, урд хэсэг цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Газрын хөрс хуурайвтар бөгөөд ялзмагийн зүйлээр бага, талын хүрэн, говийн улаан бор, цагаан бор, шаварлаг хөрсөөр бүрдсэн нутагтай, 500 шахам дүрсийн ургамал ургадаг, аргал, янгир, хар сүүлт зэрэг ховор ан амьтан, тарвага, цагаан зээр, үнэг, чоно, хярс, туулай, шилүүс, мануул зэрэг үслэг ан амьтан, тас, бүргэд, харцага, шонхор, шар шувуу, ууль, галуу, нугас, ангир, тоодог, тогоруу, ногтруу зэрэг шувуудтай. Аймгийн нутагт чулуун ба хүрэн нүүрс, шатдаг занар, хээрийн ба хайлуур жонш, гөлтгөнө, бал чулуу. Усан ба утаат ягаан болор, зэс, алт, цагаан тугалга, цайр, төмөр, мөнгө, уран, байгалийн будаг зэрэг ашигт малтмал, орд газрууд байдаг. Бүс нутгийн хөгжилд нөлөө үзүүлхүйц Хараат, Буянтын ураны, Эрээний төмрийн хүдрийн, Шар шороот, Булаг, Хөөтийн ЭРДЭС будгийн, Таргат, Ширээ уулын гөлтгөнийн болон барилгын материалын ихээхэн нөөц орд байдаг.

Аймгийн эдийн засгийн суурь салбар нь мал аж ахуй байсаар байна. Сүүлийн жилүүдэд тохиолдсон байгалийн гамшиг мал аж ахуйд хүнд цохилт өгсөн хэдий ч сүүлийн 2 жил дараалан мал сүргээ өсгөж, 2002 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймаг 1475,0 мянган толгой малтай болж, улсын нийт мал сүргийн 6,2 хувь, төвийн бүсийн малын 25.8 хувийг эзэлж байна. 2001 оны мэдээгээр нэг хүн амд ногдох малын тоогоороо төвийн бүсэд тэргүүлж байгаа бөгөөд бусад аймгуудаас 1,7-25,2 толгойгоор илүүтэй байна.

Үйлдвэрлэлийн хөгжил төдийлөн сайнгүйгээс мал аж ахуйн үнэт түүхий эдийг боловсруулалтгүйгээр гар дамжуулан арилжааны хүрээнд худалдан борлуулж орон нутгийн төсөвт орлого олох ихээхэн боломжийг алдаж байна. Аж үйлдвэрийн салбарын гол үйлдвэрлэгч нь хүнсний 2 үйлдвэр, нүүрсний 3 уурхай, дулааны 2 компани, УСАГ, гөлтгөнийн уурхай зэрэг болно.

Дундговь аймагт аялал жуулчлалын 11 гэр бааз улирлын чанартай ажиллаж байгаа бөгөөд нийгэм, соёлын салбарт хүүхдийн 20 цэцэрлэг, ерөнхий боловсролын 20 сургууль, МСҮТ, "Мандах" нягтлан бодох бүртгэлийн дээд сургууль, "Засагт хан" СЭЗДС-ийн салбарууд, нэгдсэн эмнэлэг 1, сум дундын эмнэлэг 1, сумын эмнэлэг 14, өрхийн эмнэлэг 3, хувийн хэвшлийн 2 эмнэлэг, театр киноны хүрээлэн, номын сан, музей, сумын соёлын төв болон номын сангууд үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хөгжлийн стратегид байгаль, эдийн засгийн дор дурдсан тааламжтай болон тааламжгүй нөхцөлүүд байгааг харгалзан, давуу тал дээрээ

түшиглэн, сул талаа саармагжуулах үндсэн дээр бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

Одоогийн хөгжлийн таатай нөхцөлүүд:

- Мал аж ахуйн түүхий эдийн багагүй нөөцтэй.
- Байгалийн эрдэс түүхий эдийн багагүй нөөцтэй ба улсын хэмжээний хүрэн нүүрсний нөөцийн 58,0 хувь, гөлтгөнийн 32,3 хувь, эрдсийн будгийн 53,4 хувь нь манай аймгийн нутаг дэвсгэрт байна. Мөн нефтийн илэрц бүхий талбайтай.
- Аймгийн төв болон сумдын 73,3 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон учир үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах өргөн боломжтой. 2003 оны төсөвт Адаацаг, Баянжаргалан сумдыг төвлөрсөн эрчим хүчний системд холбохоор улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаад байна. Энэ ашиглалтанд орсноор бүх сумдын 86,7 хувь нь эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдах юм.
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар олонтой ба хамгийн ойр зайд бага зардлаар говь, тал хээрийг үзэх боломж байгаа учир аялал жуулчлал хөгжүүлэх өргөн бололцоотойн дээр аялал жуулчлалын аймгийн дотоодын маршруттай болж холбогдох газраар баталгаажуулсан. 2003 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласнаар шинээр 5 газарт жуулчны гэр баазууд байгуулагдан үйл ажиллагаагаа эхлэхэд бэлэн боллоо.
- Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломж ихтэй.
- Дундговь аймаг малын гоц болон хурц халдварт өвчнөөр харьцангуй тайван.
- Гүүний айраг, хонины махны амт чанарын үзүүлэлтээр улсдаа нэрд гарсан.
- Гадаад харилцаагаа хөгжүүлэх талаар эхлэл тавьж хөрш зэргэлдээ зарим орны мужуудтай шууд харилцаа тогтоож, Америкийн хөгжлийн агентлаг, Дэлхийн зөн зэрэг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр аймгийн хөгжилд зохих нөлөө үзүүлхүйц хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна.
- Аймгийн төв Мобикомд холбогдож дэлхийн 159 оронтой харьцах боломж нээгдсэн.
- Урлаг, соёлын алдартай олон авьяастнуудыг төрүүлсэн дуу хуурын өлгий нутаг. Ялангуяа уртын дуу, морин хуурыг залуу үеийнхэнд уламжлуулах талаар ихээхэн баялаг өв туршлага хуримтлуулсан.

Өнөөгийн хөгжлийн таагүй нөхцөлүүд:

- Бэлчээрийн ургац тачир, байгалийн хадлан авах газар хомс зэргээс шалтгаалан аймгийн эдийн засгийн суурь салбар болох мал аж ахуйн хөгжил нь байгаль, цаг уурын нөхцөлөөс шууд шалтгаалдаг. Сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутгийг хамарсан байгалийн гамшигт үзэгдлийн /ган, зуд/ тоо ихэсч, мал сүрэг олноор хорогдож байгаа.
- Цаг агаарын тааламжгүй нөхцөл /ган, зуд/ ойр ойрхон давтамжтайгаар тохиолдож байгаа нь мал сүргийн өсөлт, иргэдийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байгаа.
- Эдийн засагт түшиц суурь болохуйц хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж хөгжөөгүй, татварын бааз суурь муутай.

- Ихэнх нутаг геологийн хувьд сайн судлагдаагүй, судлагдсан илэрцийн ашиглалт бага.
- Авто замын хөгжил тааруу, улсын нийслэлтэй холбогдсон зам хатуу хучилтгүй.
- Мэдлэг чадвар, боловсролтой мэргэжилтний ажиллаж амьдрах, хөгжих боломжтой орчин нөхцөл бүрдээгүй, үүнтэй уялдаж хүн амын шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж боловсон хүчний тогтвор суурьшил буурсан.
- Хүн, малын ундны усны нөөц дутагдалтай.
- Хилийн гарцгүйгээс гадаад харилцаа, худалдаа хөгжөөгүй.
- Иргэдийн дийлэнх хэсэгт газар тариалан эрхлэн хөгжүүлж амьдрал ахуйгаа дээшлүүлэх сэтгэлгээ төлөвшөөгүй.
- Зах зээлийн багтаамж муу, мөнгөний урсгалыг өөрийн аймагт татах нөхцөл бүрдээгүй.
- Эрчим хүчний хүчин чадал ашиглалтын түвшин доогуур.
- Зарим орон нутагт түлшний хүрэлцээ, хангамж сайнгүй, түлш ховордсон.
- Элсний нүүлт, цөлжилт идэвхжиж байгаа

НЭГ. ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Аймгийн хөгжлийн зорилго, зорилт тэргүүлэх чиглэл

Дундговь аймгийн хөгжлийн эрхэм зорилго нь эдийн засгийн бүсчлэлийг оновчтой тогтоож, орон нутгийн жигд хөгжлийг хангах, үйлдвэрлэл, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар экологийн баримжаатай эдийн засгийг тогтвортой хөгжүүлэн, төвийн бүсийн дэд төв болж, хүний хөгжлийн нөхцөлийг оновчтой бүрдүүлэн, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд оршино.

Энэхүү хөгжлийн бодлогын үндсэн агуулга нь өөрийн нутаг дэвсгэр дэх эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, хүн амын оюуны чадавх, биологийн төрөл зүйл, түүх соёлын өв сангаа зохистой ашиглах замаар орон нутгийн хөгжлийг хангахад чиглэгдэнэ.

Аймгийн хэтийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Мал сүргийг байгалийн эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлэх, бэлчээрийн доройтлоос сэргийлэх
- Хувийн секторыг бүх талаар дэмжин, өрсөлдөөнт зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх
- Уул, уурхайн болон мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, үйлдвэрлэлийг байгаль экологид халгүй технологи ашиглан хөгжүүлэх
- Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх гол нөхцөл болох эдийн засгийн дэд бүтцийн салбарыг түлхүү хөгжүүлэх
 - эрчим хүч
 - холбоо, мэдээлэл
 - зам

-Аялал жуулчлал

- Боловсролыг нийгмийн тэргүүлэх салбарын хэмжээнд хөгжүүлэх
Аймгийн хөгжлийн эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх стратегийн зорилтууд:
- Дундговь аймгийг төвийн бүсийн дэд төв болгон хөгжүүлэх асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ
- Орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээг иргэдийн эрэлт хэрэгцээнд ойртуулж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд бүх шатны хурал, засаг даргын ажлын албаны чадварыг дээшлүүлж, чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ
- Төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлж, нийгмийн бүхий л хүрээнд хууль тогтоомжийг сахиулах, түүний дотор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, хууль зүйн цогцолбор арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Хүний бүх талын хэрэгцээг хангах мэдээллийн орчин бүрдүүлж, мэдээллийн технологийг байнгын хэрэгцээ болгоно.
- Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын судлагдсан нөөц болон ашиглалтыг нэмэгдүүлнэ.
- Байгалийн баялгийн нөөцдөө түшиглэн экологид халгүй, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого баримтална.
- Аялал жуулчлалыг дэд бүтцийн биеэ даасан салбар болгон хөгжүүлнэ.
- Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны доройтлыг хязгаарлах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана.
- Бүсүүдийн хэмжээнд байгаль орчинд зохицон дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн хөгжих ирээдүйтэй тэргүүлэх салбарыг тогтоож, бүсүүдийн хооронд үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт, дагналтыг бий болгож хөгжүүлнэ.

Аймгийн хэтийн хөгжлийн бодлогыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

үүнд:

1. I үе шат 2003-2010 он

2. II үе шат 2011-2020 он

I үе шатанд хүний хөгжлийг бүх талаар дэмжих, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх замаар орлогоо нэмэгдүүлж, дэд бүтцээ сайжруулан, орон нутгийн жигд хөгжлийг хангах, **II шатанд** уул уурхай, мал аж ахуйн гаралтай цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлон, санхүүгийн талаар харьцангуй биеэ даан хөгжих нөхцөл бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлнэ.

Аймгийн хөгжлийн бодлогод тусгагдсан үйл ажиллагааг Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах замаар хэрэгжилтийг хангана.

Энэхүү хөгжлийн бодлого нь:

- Хөгжлийн стратеги
- Нийгмийн салбарын хөгжил
- Эдийн засгийн хөгжил

- Байгаль орчныг хамгаалах гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэнэ.

ХОЁР.НИЙГМИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

ХҮН АМЫН өсөлт, хөгжил

Одоогийн байдал:

2002 оны байдлаар аймгийн нийт хүн ам 51347 байгаа бөгөөд түүний 50,7 хувийг эрэгтэйчүүд, 49,3 хувийг эмэгтэйчүүд, 35,8 хувийг 0-16 насны хүүхэд, 36,5 хувийг 16-35 насны залуучууд эзэлж байна. Нийт хүн амд залуучуудын эзлэх хувийн жин сүүлийн 8 жилийн судалгаанаас үзвэл жилд дунджаар 0,5 хувиар өссөн байна. Нийт хүн амын 56,9 хувь нь хөдөлмөрийн насны хүн байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо жил бүр өсч, нийт хүн амд хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь нэмэгдэж байгаа нь ажиллах хүчний нөөц өссөөр байгааг харуулах эерэг үзүүлэлт юм.

Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл нийт хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо жил бүр өсөх хандлагатай байна. Энэ нь хөдөлмөрийн насны суралцагчдын тоо жил бүр нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Сүүлийн жилүүдийн судалгаагаар үзвэл 1000 хүн амд ногдох жилийн дундаж цэвэр өсөлт 1997-2000 он хүртэл 0,8-3,3 хувиар буурсан байх ба түүнээс хойших онуудад бага зэргийн өсөлт гарсан байна. 1998 оноос эхлэн суурин хүн амын тоо буурах хандлагатай байгаа нь шилжилт хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой гэж үзэж байна.

Шилжилт хөдөлгөөн их байгаагийн гол шалтгаан нь үйлдвэрлэл хөгжөөгүйгээс ажлын байр дутагдалтай, сүүлийн жилүүдэд мал сүрэг ихээр хорогдсон, хөдөөд залуучуудын тогтвор суурьшилтай ажиллах орчин бүрдээгүй зэрэгтэй холбоотой юм.

Аймгийн хөгжлийн бодлогын эцсийн зорилго нь хүний сайн сайхан аж байдлыг хангахад чиглэгдэж байгаа юм. Иймээс хүний бүх талын хөгжлийг хангах үүднээс эрүүл мэнд, хоол хүнсний баталгаатай байдал, сурч боловсрох, ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

Аймгаа хөгжүүлэх хүний нөөц чадавхыг бий болгох нь ирээдүйн хөгжлийн эх сурвалж болж байна.

Зорилт:

Хүн амаа тогтвортой өсгөж, өв тэгш хүмүүжүүлэн, хүний бүх талын хөгжлийг ханган, амьдран суурьших орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хүн амын ба хөгжлийн стратегийг нэгтгэх үүднээс нийтийн боловсрол, мэдээлэлд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж орон нутгийн чадавхыг бэхжүүлэх
- Аймгийн хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ам бүлэг сууринд жигд тархан суурьших нөхцөлийг бүрдүүлэх
- Эх нялхсын эндэгдлийг тууштай бууруулах, эсэн мэнд амаржих, өсч торних нөхцөлийг бүрдүүлэх
- Аймгийн хүн амын удмын санг хамгаалах үүднээс сөрөг нөлөө үзүүлэх бүхнээс сэргийлэх талаарх сурталчилгааг хүчтэй болгож, өрх бүрээр ургийн бичиг хөтлүүлж занших

- Хүн амын өсөлттэй холбоотойгоор хүнсний хангамжийн асуудлыг оновчтой шийдвэрлэх цогцолбор арга хэмжээ авах
- Хүн бүр өөрийнхөө хувийн хөгжилд идэвхтэй үүрэг гүйцэтгэгч байх зарчим баримтлах
- Хүүхдийг бага наснаас нь хүнсний эрүүл ахуйн дэглэмд сургаж, ухаалаг хэрэглээг төлөвшүүлэх
- Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн идэвхтэй оролцоо, санаачилга үйл ажиллагааг хөгжүүлэн дэмжих
- Хүүхдийг хүмүүжүүлж төлөвшүүлэх, өндөр настныг халамжлах, нийгмийн эрүүл мэнд, ахуйн соёлын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн гэр бүлийн хөгжилд туслах нийгмийн үйлчилгээг дэмжих
- Төрийн захиргааны байгууллагын ажилтнууд нь үйл ажиллагаагаа хүн амын гүнд төвлөрүүлж тэдэнд өөрсдийн хөдөлмөр зүтгэлээр ажиллаж амьдрах арга ухааны дадал заншлыг эзэмшүүлэх замаар хүн хүчний нөөцийг хөгжүүлэх, түүнийг зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.
- Төрийн албан хаагчдыг чадваржуулах, бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Оюуны өндөр чадавхтай залуу мэргэжилтнүүдийн цаашид сурах, хөгжихөд нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж аймгаа хөгжүүлэхэд тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Аймагт шаардлагатай зарим мэргэжлээр өндөр хөгжилтэй орнуудад боловсон хүчин бэлтгэх
- Бага насны хүүхдийн авъяасыг илрүүлж гоц авъяастай хүүхдийг тэр чиглэлээр нь хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Иргэдийн эрүүл аж төрөх, урт наслах, тасралтгүй сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгэм, соёлын амьдралд тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг баримтлах.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгож нийгэм, соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулах арга хэмжээ авах.
- Жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар эмэгтэйчүүдийн эрхийг хүндлэх, хамгаалах, хүйсийн тэгш байдал, тэгш эрхийг дэмжихэд чиглэсэн системтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Өсвөр насныханд нөхөн үржхүйн эрүүл мэндийн талаар боловсрол олгох үйлчилгээ бий болгож тэдэнд тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх
- Хүний хүчин зүйлээс байгаль орчинд учруулдаг сөрөг нөлөөг багасгах
- Тахир дутуу хүмүүст тэгш бололцоо олгоход чиглэсэн нөхцөл бий болгон тэдний эдийн засаг, нийгмийн хөгжлийн үйл явцад оролцох чадварыг нь дээшлүүлэх
- Хүүхэд, залуучуудад үзүүлэх ядуурлын сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Залуучуудын албан ба албан бус боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, эрүүл мэндийн хэрэгцээг нь хангаж, тэднийг нийгмийн амьдралд оролцоход биеэ бэлтгэхэд нь туслах

ХҮН АМЫН НУТАГШИЛ, СУУРЬШИЛ

Эдийн засгийн бүсчлэг **Одоогийн байдал:**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 1 хот /аймгийн төв/, 1 хоторхуу тосгон /Тэвшийн говь/, 15 хөдөөгийн тосгон /сумдын төв/ тус аймгийн нутагшилтын өнөөгийн тогтолцоог бүрдүүлж байгаа бөгөөд 2002 оны байдлаар хот, төв суурингуудад 18,4 мянган хүн оршин сууж байна.Энэ нь аймгийн нийт хүн амын 35,9 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд хүн амын нутагшилтын нэг мөр болсон тогтолцоо байхгүйгээс төв суурингууд нь голчлон засаг захиргааны хувьд өөрийн аймгийн төвтэй холбогдохоос бус үйлдвэрлэл, үйлчилгээ хангамжийн хувьд аймагтай чөлөөтэй харьцах боломж хязгаарлагдмал байна. Энэ нь нутагшилт, хот байгуулалтын бодлогын нэгэн дутагдал юм.

Аймгийн доторх бүсчлэлийн схемийг орон нутгийн дэд бүтэц, ашигт малтмал, хүн амын нягтрал, эдийн засгийн харилцаанд тулгуурлан эдийн засгийн төв бүсийн хөгжилтэй уялдуулан боловсруулж хот байгуулалтын үнэлгээг үндэслэн сум, суурин газрын төвүүдийн хэтийн төлвийг тодорхойлох нь тулгамдсан асуудал болж байна.

Эрх бүхий яам, газруудаас боловсруулсан Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх баримт бичиг, төслүүдэд Дундговь аймгийг төвийн бүсийн нутгийн говийн дэд бүсэд хамруулан авч үзсээр ирсэн бөгөөд УИХ-аас 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д эдийн засгийн төвийн бүсэд хамруулсан билээ.

Манай аймаг говийн бүсийн аймгаас нийслэлд хамгийн ойр, төвийн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд ирээдүйд Чойроос Өвөрхангайн Баянтээгийн уурхай хүртэл тавих төмөр зам дайран өнгөрөх, авто замын хөндлөн тэнхлэгт холбогдох төсөөлөлтэй байгаа, цаашид Улаанбаатар, төвийн бүсийн тулгуур төв болох Зуунмод хотын ард иргэдийг чанар сайтай мах, махан бүтээгдэхүүн, айраг хоормогоор тодорхой хэмжээгээр хангах, ашигт малтмалын судлагдсан болон судлагдаагүй баялаг нь аймгийн төдийгүй улс орон, бүсийн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлэх илэрц, нөөцтэй зэрэг нь төвийн бүсийн хөгжилд тодорхой байр суурь эзлэн төвийн бүсийн дэд төв болох магадлалтай гэж үзэж байна.

Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх бодлого хэрэгжиж эхлээд байгаатай уялдуулан хүн амын амьдрах экологи, нийгмийн таатай орчинг бүрдүүлэх, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл үйлчилгээг сонгон хөгжүүлэх, сум, багийн хоорондын аж ахуйн хоршилт, дэд бүтцийн уялдааг хангах асуудлыг шийдвэрлэх үүднээс нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын хүчин чармайлтыг нэгтгэн зохион байгуулах шаардлагатай байгаа билээ.

Зорилт:

Бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатайгаар дээшлүүлэн, бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангаж, засаг захиргааны байгууламжийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бүсчилсэн хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, хэрэгжүүлэх журам, зааврыг аймгийн ИТХ-аас батлан гаргаж хэрэгжүүлэх
- Бүс нутгийн эдийн засаг, нийгмийн тэргүүлэх чиглэлийг тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Бүсийн хөгжлийн таталцлыг оновчтой тогтоож, бүсийн төвийг төрийн бодлогоор дэмжин, дэд бүтцийн хөгжлийн асуудлыг дэс дараатайгаар шийдвэрлэх
- Бүсүүдийн зөвлөлийг нэгтгэн удирдаж, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг нь хооронд нь уялдуулан зохицуулах үүрэг бүхий удирдлагын зөвлөлийг аймгийн ИТХ-ын харъяанд ажиллуулах
- Бүсүүдийн хөгжлийн явцад нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагын оновчтой бүтцийг бүрдүүлэх эрх зүйн орчин буй болгох
- Бүсийн төвүүдийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх
- Бүсийн төвүүдийг бөөний худалдааны сүлжээнд оруулах
- Бүсүүдийн онцлогт нийцүүлэн үйлдвэрлэлийг төрөлжсөн, дагнасан хэлбэрээр хөгжүүлэх
- Бүсийн төвүүдэд хамгаалалтын зурвас, ногоон байгууламж байгуулж мод тарих, хөрсний эвдрэлийг багасгах төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Бүсүүдийн хөгжлийг хөрөнгө оруулалт, мөнгө, зээлийн бодлогоор дэмжих
- Уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд хамтран ажиллах явдлыг дэмжих
- Мандалговь хотыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх
- Байгаль газарзүйн онцлог, байршил, үйлчилгээний хангамжийн хүрээ, төв суурины хот байгуулалтын үнэлгээ, хүн ам, эдийн засгийн хөгжлийн боломж зэргийг харгалзан сумдыг 3 бүс болгон хөгжүүлэх
- Бүсүүдийг хооронд нь болон аймгийн төвтэй холбож чадахуйц дэд бүтцийн тогтолцоог бүрдүүлэх
- Бүс нутгийн хөгжлийг дэмжих сан байгуулж ажиллах
- Бүсэд хамаарах сумдын хуваарийг дараах байдлаар тогтоож, сум хоорондын аж ахуйн болон нийгэм, соёлын холбоо харилцааг сайжруулах

Баруун бүсэд: Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Адаацаг

Төвийн бүсэд: Дэлгэрцогт, Өлзийт, Хулд, Луус, Сайнцагаан

Зүүн бүсэд: Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан

А/Баруун бүс Одоогийн байдал:

Бүсийн төв Эрдэнэдалай сумын төв Сангийн далай аймгийн төвөөс 109 км алслагдсан, далайн түвшнээс 1400 м-т өргөгдсөн, харъяалагдах сумдын төв нь аймгаас 104-210 км-т оршдог. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй, Адаацагаас бусад бүх сумд эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон.

Адаацаг сум 2003-2004 онд холбогдохоор улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан. Бүс 2091,4 мянган га /28,0%/ нутаг дэвсгэртэй, 15,9 мянган /30,9%/ хүн амтай, 433,6 мянган /29,4%/ толгой малтай.

Тус бүс үхрийн тоогоор бусдаас илүү бөгөөд аймгийн нийт үхрийн 37,1% нь энд хамрагдана. Цагаан-Овоогийн нүүрсний уурхай, Таргатын гөлтгөнийн уурхай энэ бүсийн нутаг дэвсгэрт байрладаг, чулуун нүүрс, гөлтгөнө, давс, алтны нөөцтэй, аялал жуулчлалын 8 баазтай, ан агнуурын нөөц газартай.

Бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Цагаан-Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэлт хийж олборлолтыг нэмэгдүүлэн баруун болон төвийн бүсийн хэрэгцээг хангах
 - Таргатын гөлтгөнийн уурхайн бүтээгдэхүүнд тулгуурлан Дэлгэрхангай суманд цементийн, гипсэн хийцийн жижиг үйлдвэр байгуулан говийн аймгуудад нийлүүлэх, тус сумыг баруун бүсийн үйлдвэрлэлийн төв болгох
 - Эрдэнэдалай сумын Цагаан хадны алтны уурхайн нөөц газарт нарийвчилсан хайгуул хийлгэж ашиглах
 - Сайхан-Овоогийн Бяруут, Эрдэнэдалайн Сангийн далайн давсны ордуудыг ашиглаж иоджуулсан давс бэлтгэж бүсийн болон аймгийн хэрэгцээг хангах
 - Аялал жуулчлалын бүсийн дотоодын маршрутыг бий болгож аймгийн болон улсын нэгдсэн сүлжээнд хамруулах
- ❖ Сайхан-Овоо сумыг баруун бүсийн аялал жуулчлалын түшиц газар болгон хөгжүүлэх
 - ❖ Дэлгэрхангай сумын агнуурын нөөц бүхий нутагт ан агнуур хийх замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх
 - ❖ Эрдэнэдалай суманд мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэр /эсгий.эсгий гутал/ байгуулах
 - ❖ Эрдэнэдалай суманд утаагүй шахмал түлшний үйлдвэр байгуулах
 - ❖ Эрдэнэдалай суманд шинээр сум дундын эмнэлэг барьж, үйлчилгээг өргөтгөх
 - ❖ Сайхан-Овоо суманд жимс, жимсгэний аж ахуй байгуулах
 - ❖ Адаацаг сумыг бүсийн мал аж ахуйн бааз болгох бөгөөд хадлангийн иж бүрэн салаатай болж, тэжээлийн жижиг цех байгуулах
 - ❖ Адаацаг сумыг төвлөрсөн эрчим хүчний системд холбох
 - ❖ Бүсийн бүх сумдад төмс, хүнсний ногооны тариалалтыг эрчимжүүлж, удаан хадгалах, зах зээлд борлуулах нөхцөлийг бүрдүүлэх
 - ❖ Сайхан-Овоо суманд усалгаатай тариалан эрхлэх

Б/Төвийн бүс Одоогийн байдал:

Бүсийн төв Мандалговь хот Улаанбаатар хотоос урагш 265 км алслагдсан, далайн түвшнээс дээш 1500 метрт өргөгдсөн. Бүсэд багтах сумын төвүүд аймгаас 44-98 км алслагдсан, эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй, 3056,0 мянган га нутагтай / 40,9%/, 24,2 мянган хүн амтай /47,0%/, 556,2 мянган толгой малтай /37,7%/ Тус бүс нь газар нутаг, хүн ам, мал сүргийн тоо хэмжээгээр баруун, зүүн бүсээс харьцангуй илүүтэй байгаа хэдий ч нэг хүнд ногдох малын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээгээр бусдаас доогуур үзүүлэлттэй байна. Энэ бүс тэмээгээр тэргүүлдэг бөгөөд нийт тэмээний 50,4 хувь нь энд хамрагдаж байна.

Энэ бүсэд жилд 50000 тн нүүрс олборлох хүчин чадалтай Тэвшийн говийн нүүрсний уурхай, хүнсний үйлдвэрлэлийн Говийн тэнгэр, Мандалговь Хүнс, дулааны Ган-Илч, Говийн гал компаниуд болон соёл, боловсрол, биеийн тамир спорт, үйлчилгээний гол төвүүд байрладаг.Шохойн чулуу, боржин чулуу, тоосгоны шавар, шаварлаг занар, хүрэн нүүрс, цагаан тугалга, уран, алт, нефтийн ордуудтай. Аялал жуулчлалын 4 бааз, нэг ээлжинд 200 хүүхэд хүлээн авах хүчин чадал бүхий зуслантай.Өлзийтөөс бусад сум төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон.

Бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ❖ Тэвшийн говийн нүүрсний олборлолтыг нэмэгдүүлэн бүс болон төвийн бүсийн зарим аймгийн хэрэгцээг хангах
- ❖ Мандалговь хотод тоосгоны үйлдвэр байгуулж өөрийн болон говийн зарим аймгийн хэрэгцээг хангах
- ❖ Дэлгэрцогт сумын эсгийний цехийг эсгий эсгий гутлын үйлдвэр болгон өргөтгөж бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах
- ❖ Аялал жуулчлалын бүсийн маршрут бий болгож аймгийн сүлжээнд хамруулах
- ❖ Бага газрын чулууны уулын орчим дахь аялал жуулчлалын баазуудыг түшиглүүлэн нисэх онгоцны буудал байгуулах
- ❖ Мандалговийн нисэх онгоцны буудлыг шинэчлэх
- ❖ Мандалговь хотын ундны цэвэр усан хангамжийн эх үүсвэрийг гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх
- ❖ Мандалговь хотод утаагүй шахмал түлш Дэлгэрцогт суманд цагаан тугалганы үйлдвэр байгуулах
- ❖ Өлзийт суманд сум дундын отрын бүс байгуулах
- ❖ Өлзийт суманд ингэний сүү боловсруулах цех байгуулах
- ❖ Өлзийтийн алтны ордод нарийвчилсан судалгаа хийж, үндсэн ордны үйлдвэр байгуулах
- ❖ Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус сумдад төмс, хүнсний ногооны тариалалтыг эрчимжүүлж, удаан хадгалах, зах зээлд борлуулах нөхцөлийг бүрдүүлэх
- ❖ Өлзийт, Хулд сумд дахь нефтийн талбайд хайгуул хийж нөөцийг тогтоолгон ашиглах

В/Зүүн бүс Одоогийн байдал:

Эдгээр сумд аймгийн төвөөс 66-180 км алслагдсан, эдийн засагт голлох үүргийг мал аж ахуйн салбар гүйцэтгэдэг, сумдын 33,3 хувь /Баянжаргалан, Өндөршил/ эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй, 2321,6 мянган га нутагтай /31,1%/, 11,3 мянган хүн амтай /22,1%/, 485,2 мянган толгой малтай /32,9%/. Бүсийн төв нь Говь-Угтаал сум байх болно.

Зүүн бүс нь хүн ам цөөнтэй, нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээ, малын тоогоор бусад бүсээс нилээд өндөр үзүүлэлттэй. Энэ бүс одоогийн судлагдсан түвшинд ашигт малтмалын нөөц илүүтэй ба тэнд гантиг чулуу, уран, эрдсийн будаг, жонш, нүүрс, шатах занар зэрэг ашигт малтмалын нөөц ордуудтай, аялал жуулчлалын 2 баазтай.

Бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ❖ Говь-Угтаал, Гурвансайхан сумдад мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэр байгуулах
- ❖ Аялал жуулчлалын бүсийн дотоодын маршрутыг бий болгож аймгийн болон улсын нэгдсэн сүлжээнд хамруулах
- ❖ Өндөршил, Баянжаргалан сум, Хөөтийн уурхайг эрчим хүчний төвлөрсөн системд холбох
- ❖ Ан агнуурын нөөц бүхий нутагт ан агнуур хийх
- ❖ Дэрэн суманд гүүний саам, айраг боловсруулах цех байгуулах
- ❖ Хөөтийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэлт хийж олборлолтыг нэмэгдүүлэн бүсийн нүүрсний хэрэгцээг хангах

- ❖ Говь-Угтаал, Баянжаргалан сумдад төмс, хүнсний ногооны тариалалтыг эрчимжүүлж, удаан хадгалах зах зээлд борлуулах нөхцөл бүрдүүлэх, Өндөршил суманд тарвас тариалах
- ❖ Цагаандэлгэрийн барилгын материалын ордын нөөцийг шинэчлэн тогтоож, эрдэс будгийн үйлдвэр байгуулан аймгийн хэрэгцээг хангах
- ❖ Эрээний төмрийн хүдэр, Хөөтийн нүүрсний уурхайн ашиглалттай холбогдуулан Шивээговь-Хараатын чиглэлд 60 км төмөр зам тавих
- ❖ Гурвансайхан суманд үнэт чулууны үйлдвэр байгуулах
- ❖ Говь-Угтаал сум-нд шинээр эмнэлэг барьж сум дундын үйлчилгээтэй болгох
- ❖ Гурвансайхан сумыг бүсийн аялал жуулчлалын бааз газар болгон хөгжүүлэх
- ❖ Баянжаргалан сумыг бүсийн үйлдвэрлэлийн район болгох
- ❖ Цагаандэлгэр суманд бүсийн спортын цогцолбор байгуулах

- ❖ Өндөршил сумын соёлын төвийг өргөтгөн бүсийн үйлчилгээтэй болгох
- ❖ Баянжаргалан суманд сум дундын нийтийн аж ахуйн үйлчилгээний баазтай болох

Орон сууц хангамж

Одоогийн байдал:

2000 оны хүн ам орон сууцны тооллогын дүнгээр үзвэл аймгийн нийт өрхийн 11,7 хувь буюу 1437 өрх орон сууцанд амьдарч байна. Үүний 831 нь тусдаа байшинд, 463 нь сууцны байшин доторх сууцанд байгаа ба 76,7 хувь нь хувийн орон сууц юм. Орон сууцны талбайгаар үзвэл 25,2 хувь нь 20 хүртэл кв.м, 31,7 хувь нь 21-30 кв.м, 43,1 хувь нь 31-ээс илүү кв.м талбайтай байна.

Өрөөний хувьд 33,4 хувь нь нэг өрөө, 66,6 хувь нь 2-оос дээш өрөөтэй байна. Аймгийн хүн амын 12,1 хувь нь байшинд, 87,9 хувь нь гэрт амьдарч байна. Нийт орон сууцны 28,1 хувь нь төвлөрсөн халаалтын, 25,8 хувь нь цэвэр бохир усны системд холбогдсон ба 29,9 хувь нь дотроо бие засах газартай, 86,4 хувь нь гал тогооны өрөөтэй, 16,8 хувь нь банны өрөөтэй байна.

2000 онд Мандалговь хотын орон сууцны хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

Орон сууцны 3 төрөл байна. Үүнд: улсаас баригдсан орон сууцны байр /ихэнх нь хувьчлагдсан/, гэр ба зуны модон байшингууд, жилийн дөрвөн улирлын турш амьдарч болох амины орон сууц.

Монгол Улсын иргэн "...эрүүл. аюулгүй орчинд амьдрах эрхтэй..." гэсэн Үндсэн хуулийн заалт нь хүний амьдарч, аж төрөх ахуй орчныг бүрдүүлэгч орон сууцанд тавигдаж байгаа үндсэн шаардлага юм.

Зорилт:

Орон сууцны хангамжийг сайжруулж, өрх бүрийг эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орон сууцаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- ❖ Азийн хөгжлийн банкны "Орон сууцны зээл" төсөлд хамрагдан орон сууцны хангамжийг үе шаттай нэмэгдүүлэх, одоо байгаа орон сууцны чанарыг сайжруулах

- ❖ Орон сууцыг төлөвлөх, барих үйл ажиллагаанд хот байгуулалт, архитектур, барилгын эрүүл ахуй, экологи, аюулгүй байдал, оршин суугчдын эрх ашгийг харгалзах
- ❖ Монгол гэрийг суурин хэвшлийн амьдралын эрүүл ахуй, хүрээлэн байгаа орчин, хот байгуулалтын үндсэн шаардлагуудтай уялдуулан хөгжүүлэх
- ❖ Аймаг, сумын төвийн гэр хороолол дах орон сууцыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- ❖ Хүн амд орон сууцны зориулалтаар газар олгож, барилга барих шинэ технологид сургах замаар амьдралаа дээшлүүлэхэд нь туслах
- ❖ Орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ❖ Мэргэжилтний сууцнаас бусад орон нутгийн өмчийн сууцыг хувьчлах
- ❖ Төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- ❖ Төвлөрсөн системд холбогдсон бүх орон сууцыг халуун устай болгох
- ❖ 2010 оны түвшинд хүн амын 20%, 2020 онд 30%-ийг орон сууцаар хангах бодлого баримтлах
- ❖ Орон сууцны хорооллыг нягтруулж, төв суурин газрын дэд бүтцийн үр ашгийг дээшлүүлэх бодлого баримтлах
- ❖ Орон сууцны бодит хөгжлийг дэмжих санхүүгийн нөөц бололцоог нэмэгдүүлэх Сум бүрт мэргэжилтний орон сууцны асуудлыг шийдэх.

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Одоогийн байдал:

Аймгийн Эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн газар, түүний харъяа Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг 1, сумын эмнэлэг 14, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 2, оргүй 7 эмнэлэг ажиллаж байна. Сум бүрт эргэлтийн эмийн сантай.

Аймгийн төвд 2002 онд 3 өрхийн эмнэлэг байгуулагдан 12600 гаруй иргэнийг бүртгэлдээ авснаар эрүүл мэндийн анхан шатны тусламжийн чанар хүртээмж нэмэгдэж улмаар төвлөрсөн хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөл, хүүхдийн өвчлөл, эндэгдэл буурах, эх нялхаст үзүүлэх тусламж сайжрах нөхцөл бүрдлээ.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн үндэсний 12 хөтөлбөр хэрэгжиж, хүн амын дунд хийгдэх урьдчилан сэргийлэх үзлэгийн дүн жилээс жилд нэмэгдэж байна.

Өнөөгийн байдлаар Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумын иргэд Өвөрхангай аймгийн "Бүсийн оношилгоо шинжилгээний төв"-д харъяалагдан үйлчлүүлж байна.

Баруун бүсийн сумдын иргэдийг Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгээр бүрэн үйлчлүүлэх, сум дундын эмнэлгийн нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор тоног төхөөрөмжөөр хангах эмч мэргэжилтнийг сургах мэргэшүүлэх ажил хийгдэж байна.

2002 оны байдлаар 1000 хүн амд ногдох төрөлт 19,3, нас баралт 5,0, цэвэр өсөлт 14,3, нялхсын эндэгдэл 26,9 байна.

10000 хүн амд их эмч 18,5, дунд мэргэжилтэн 56,9, нэг их эмчид 539 хүн ногдож байна.

10000 хүнд ногдох халдварт өвчлөл 117 байгаагаас вируст гепатит, салхин цэцэг, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэ, улаанууд зэрэг нь төдийлөн буурахгүй байна.

Халдварт бус өвчлөл , амьсгалын тогтолцооны , хоол боловсруулах замын , цусны эргэлтийн тогтолцооны, бөөр шээсний замын өвчин болон осол гэмтэл хүн амын өвчлөлд тэргүүлэх байр эзэлж байна.

Нас баралтын шалтгаанд зүрх судасны өвчин, хавдар зонхилж байна.

Аймагт Биеийн тамир, спортын хороо, Эрүүл мэндийн газарт нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төв ажиллаж хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, үндэсний сурын спортыг хөгжүүлэх зэрэг дэд хөтөлбөрүүдийг боловсруулан мөрдөж, өөрийн аймагт түлхүү хөгжүүлэхээр сонгон авсан спортын 11-14 төрлөөр улс аймгийн тэмцээн уралдааныг зохион байгуулж оролцохоос гадна спортын 6 төрлийг клубийн системд шилжүүлж тэднийг дэмжин үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорилт:

1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлнэ.
2. Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлнэ.
3. Эх хүүхэд, ахмад настны эрүүл мэндийг сайжруулна.
4. Орчны бохирдол хордолтоос шалтгаалсан эрүүл мэндийн эрсдэлийг бууруулна.
5. Хүн амын дунд зонхилох шалтгаан болж байгаа өвчлөл, нас баралтыг бууруулна.
6. Эмнэлгийн хувьчлалыг явуулах замаар өрсөлдөөн бий болгоно.
7. Хүн амыг нийтийн биеийн тамирын арга хэмжээнд өргөн хамруулж, бие бялдрыг чийрэгжүүлэн, тэдний эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэн, үндэсний хэмжээнд амжилт гаргах спортын төрлийг нэмэгдүүлж, орчин үеийн спортыг хөгжүүлэн, материаллаг баазыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй, энгийн арга хэлбэрээр өөрсдийг нь оролцуулах замаар эрүүл мэндийн анхны тусламжийг хөгжүүлэх
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэдэг зан үйлтэй болгох ажиллагааг бүх талаар дэмжиж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх
- Эрүүл мэндийн салбарын тогтолцоог нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглүүлэн боловсронгуй болгож нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийх
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийг говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв болгох, теле анагаах сүлжээнд холбогдох
- Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын эмнэлгийг сум дундын эмнэлэг болгон хөгжүүлэх, шинээр эмнэлгийн барилга барих, тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангах Өрхийн эмнэлгийн тогтолцоог төлөвшүүлэх Сумын эмнэлгийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Сум дундын бүсийн эмнэлгүүдийг оношилгоо - эмчилгээний чадамж бүхий эмнэлэг болгох

- Хүн ам төвлөрсөн багийн эмнэлгийг ортой, унаатай, их эмчтэй болгож эрүүл мэндийн даатгалд хамруулан үйлчилгээг өргөжүүлэх
- Эмч нарын тогтвор суурьшлыг сайжруулахын тулд цалин хөлс, орон байраар хангах, магистр, докторантурт сургах, зэрэгтэй эмч нарын тоог нэмэгдүүлэх
- Эх хүүхэд, ахмад настны эрүүл мэндийг сайжруулахад нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хамт олны оролцоонд тулгуурлах
- Эхэд ээлтэй эмнэлгийг бий болгох, хүүхдэд ээлтэй эмнэлгийн тоог нэмэгдүүлэх
- Ахмад настан, суурь өвчтэй хүүхдийн сувилал байгуулах
- Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвүүдийг бий болгох
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, гаралтыг бууруулах
- Өргөн вакцинжуулалтыг 95%-д хүргэж салхин цэцэг, гахайн хавдрын өвчлөлийг бууруулах
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, усан хангамж, хүнсний аюулгүй байдлыг хангах замаар вируст гепатит, гэдэсний халдварыг бууруулах
- ДОХ, бэлгийн замын халдварт өвчний мэдээлэл, сургалт сурталчилгааг сайжруулж, оношилгоо эмчилгээг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хийх, эмчлүүлэгч үйлчлүүлэгчид эмнэлэг, эмчийг сонгох орчин нөхцөлийг бүрдүүлэх
- Эрүүл хот төсөл хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийг дэмжигч баг, албан байгууллага, айл өрх бий болгох Аймаг сумын төвийн хүн амын ундны усанд хийх хими, нян судлалын шинжилгээг тогтмолжуулах
- Ундны усны хангамжийг сайжруулах, ус цэвэршүүлэгч тоног төхөөрөмж өргөн хэрэглэх
- Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
- Зүрх судасны эмгэгийг эрт илрүүлэх оношилгоо эмчилгээний чанарыг сайжруулах
- Хавдар өвчнийг эрт илрүүлэх, оношилгоо эмчилгээний чадавхыг дээшлүүлэх
- Хавдар өвчтэй хүмүүсийг хөнгөвчлөх эмчилгээнд хамруулах
- Амьсгал, хоол боловсруулах , бөөр шээсний замын өвчний оношилгоо эмчилгээний чанарыг сайжруулах, эрүүлжүүлэх арга замыг хэрэгжүүлэхэд анхаарч төрөлжсөн сувилал байгуулах
- Нэгдсэн эмнэлгийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх
- Нэгдсэн эмнэлгийг менежментийн хэлбэрээр хувьчлах
- Сумын эмнэлгийг хувьчлах
- Одоо ажиллаж буй хувийн эмнэлгүүдийг өргөжүүлэх, хамтарч ажиллах асуудлыг зөв хувилбараар шийдвэрлэж өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх
- Шинээр хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан байгуулах явдлыг дэмжих
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн сүлжээ байгуулах
- Эмийн бус эмчилгээний аргыг өргөн нэвтрүүлэх
- Сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг нийтийн биеийн тамирын арга хэмжээнд өргөнөөр хамруулан тэдний идэвх санаачилгыг өрнүүлж бие бялдрыг хөгжүүлэх, спорт-аяллыг зохион байгуулах ажлыг тогтмолжуулан, иргэдийг биеийн тамир, спортоор бие даан хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх, мэдлэг чадвар, дадлагатай болгох, сургалт сурталчилгааны ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох

- Спортын секц, дугуйлангийн чанарыг сайжруулж, уралдаан тэмцээнийг үе шаттай тогтмол явуулж тамирчдын спортын цол, зэрэг амжилтыг ахиулан спортын алдартнуудын эгнээг өргөтгөх
- Хүн амын бие бялдрын хөгжил, орон нутгийн уламжлал, байгаль цаг агаарын онцлог, боловсон хүчний чадавх, материаллаг бааздаа түшиглэн үндэсний болон орчин үеийн спортын төрлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шинээр спортын цогцолбор, ордон, усан бассейн, бие бялдрыг бялдаржуулах төв байгуулах ажлыг дэс дараатай шийдвэрлэх
- Биеийн тамир, спортын материаллаг баазыг зориулалтын дагуу ашиглах нөхцөлөөр хувьчлах

БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАР

Одоогийн байдал:

Аймгийн боловсролын салбарыг 2002-2005 онд хэрэгжүүлэх стратегийг боловсруулан баталж, боловсролын салбарт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх Албан бус боловсролыг хөгжүүлэх, Бүх нийтийн экологийн боловсрол, Эрүүл мэндийн боловсрол, Техникийн боловсрол мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх, Сургуулийн өмнөх боловсрол-2, Зайны сургалтыг хөгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж, 2003 онд сум бүр боловсролын салбараа хөгжүүлэх хэтийн бодлого чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 21 цэцэрлэг, ерөнхий боловсролын 20 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс бага сургууль-1, суурь боловсрол олгох сургууль-13, бүрэн дунд боловсрол олгох сургууль-6 ажиллаж байна. Үүний нэг нь математикийн гүнзгийрүүлсэн сургалттай сургууль юм.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нягтлан бодох бүртгэлийн "Мандах дээд сургуулийн салбар, Засагт хан СЭЗДС-ийн сургалтын төв тус тус ажиллаж байна.

ЕБС-д 331 бүлэгт 9790 хүүхэд суралцаж, 387 багш, хүүхдийн цэцэрлэгт нийт 75 багш сургалт хүмүүжлийн ажил явуулж байна.

ЕБС-ийн багш нарын 85,2 хувь буюу 330 нь мэргэжлийн, цэцэрлэгийн багш нарын 51 хувь буюу 40 нь бага насны хүүхэдтэй ажиллах мэргэжил эзэмшсэн, 49 хувь буюу 39 нь мэргэжлийн бус багш нар байгаагийн дийлэнх хувь нь хөдөө сумдад ажиллаж байна.

ЕБС-ийн багш нарын 135 нь буюу 34,8 хувь нь, СӨБ-ын багш нарын 24 нь буюу 30,3 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байгаагаас гадна Монгол улсын гавьяат багш 2, Боловсролын тэргүүний ажилтан 60 гаруй ажиллаж байна.

Дотуур байрны ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлснээр аймгийн хэмжээнд дотуур байранд амьдрах шаардлагатай хүүхдийн 74,8 хувь нь дотуур байранд амьдарч байна.

Аймгийн хэмжээнд гүнзгийрүүлсэн сургалттай сургалтад 489, төрөлжсөн сургалттай сургалтад 735 хүүхэд хамрагдсан нь суралцагсдын 12,8 хувийг эзэлж байна.

Цэцэрлэгийн насны хүүхдийн 49 хувь буюу 2812 хүүхэд цэцэрлэгт хамрагдаад байна.

"Мандах" бүртгэл болон "Засагт хан" дээд сургуулиудын салбар, сургалтын төвд 200 гаруй оюутан, залуучууд суралцаж байна.

МСҮТ-ийг хүн амын боловсролын хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн үйл ажиллагааг нь өргөтгөн БСШУЯ-ны дэргэдэх албан бус боловсролын төвтэй хамтран модуль сургалтын хөтөлбөрийг тогооч, оёдлын чиглэлээр боловсруулан хичээллүүлж байна.

Боловсрол, соёлын салбарт 2002 онд 1278473,8 мянган төгрөг, үүнээс цэцэрлэгт 996144,6, ЕБС-д 966625,4 мянган төгрөгийн төсөв зарцуулсан нь аймгийн нийт төсвийн 36,7 хувийг эзэлж байна.

2003 онд улсын төвлөрсөн төсвөөс 2 сургууль, 1 дотуур байрны их засварт 38,0 сая, Цагаандэлгэр сумын сургуулийн спорт заалны барилга шинээр барих, Эрдэнэдалай сумын сургуулийн дотуур байр, Дэрэн сумын соёлын төвийн барилгыг дуусгах ажилд 199,6 сая, Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр, Нордикийн сан, Английн хүүхдийг ивээх сан, Тогтвортой амьжиргаа хөтөлбөрийн хүрээнд 5 сумын сургууль, дотуур байр, нэг цэцэрлэгийн барилгын их засвар, нэг цэцэрлэгийн барилга-шинээр барихад 378,9 сая буюу нийт 616,5 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн хийж эхлээд байна.

Английн хүүхдийг ивээх сантай 2005 он хүртэл хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаар Боловсрол.соёлын газрын дэргэд СӨБ-ын агуулга арга зүйн төв, Дэрэн суманд цэцэрлэгийн барилга барих, 6 суманд гэр цэцэрлэг бий болгох, 9 сумын 10 цэцэрлэгт тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлэхэд 40 шахам сая төгрөгийн төсөл хэрэгжүүлээд байна.

Соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх аймгийн музей, театр киноны хүрээлэн, төв номын сан, сумдад соёлын төв, номын сан ажиллаж байна.

Аймгийн музей 8 танхимтай, 3000 гаруй үзмэртэй, жилдээ 6000 орчим хүнд үйлчилдэг. Байгаль, түүх орон нутгийн судлалын чиглэлээр ажилладаг. Археологийн дурсгалаар баян бөгөөд хүрлийн үеийн цуглуулгаар улсад тэргүүлдэг. Аймгийн музей 1999 онд аймгийн тэргүүний хамт олноор шалгарсан.

Алдарт гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн нэрэмжит аймгийн төв номын сан нь 53000 номын фондтой, 3 тасагтай, 37 нэр төрлийн хэвлэл тогтмол захиалж иргэдэд үйлчилдэг, жилдээ 4000 гаруй хүнд үйлчилдэг.

Аймгийн театр киноны хүрээлэн нь 4 анги, 50 уран бүтээлч, ажилтнуудтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Жилд дунджаар 3-5 уран бүтээл шинээр туурвин бүтээж өөрийн болон гадны аймгуудын 15000 орчим иргэдэд соёл, урлагаар үйлчилж байна 2003 онд аймгийн тэргүүний хамт олноор шалгарсан.

Тус театрын тайзнаас Монгол Улсын гавьяат жүжигчин 6, соёлын тэргүүний ажилтан 16 хүн тус тус төрөн гарсан байна.

Улсын тэргүүний уран сайханчдын аймгийн зөвлөлгөөнийг зохион байгуулж, 78 авьяастны тайлан тоглолтыг 2001 онд хийж, жил бүр авьяастнуудын дунд 6 төрлийн уралдаан наадмыг уламжлал болгон явуулж байна.

Зорилт:

1. Тасралтгүй сурч, ажиллах, амьдрах чадвартай, өв тэгш хүмүүжилтэй, оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, эрүүл чийрэг бүтээлч сэтгэлгээтэй иргэн төлөвшүүлэх таатай орчин бүрдүүлнэ.
2. Ерөнхий боловсролын сургуулиудыг 11 жилийн тогтолцоонд шилжүүлж, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан мэргэжлийг хослуулна.
3. СӨБ-ын олон хувилбарт оновчтой тогтолцоог бий болгон сургалтын орчинг бүрдүүлнэ.

4. Боловсрол, соёлын байгууллагуудыг хувьчлах, хувийн сургууль, цэцэрлэг, соёлын байгууллага байгуулах үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлнэ.
5. Сургууль, цэцэрлэгийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, багш удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тэдний нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээ авна.
6. Нийгмийн шаардлага, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хүн амд хэрэгцээтэй боловсролыг сургуулиас гадуур тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаанд нь тасралтгүй эзэмшүүлэх тогтолцоо бүрдүүлнэ.
7. Аймаг сум, сургуулийн түвшинд боловсролын стандартын хэрэгжилтийг хангах ажлыг боловсронгуй болгоно.
8. Үндэсний соёл, ёс заншлыг хамгаалж өвлүүлэн, уламжлалт ардын язгуур урлагийг түлхүү хөгжүүлэн түгээн дэлгэрүүлж, залуу авьяастнуудыг чадваржуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бүх сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдэд дэс дараатайгаар их засвар хийж, үйл ажиллагаа явуулах, тохитой орчинг бүрдүүлэх
- Боловсролын байгууллагуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр ханган компьютержүүлж интернетээс мэдээлэл авах боломж бүрдүүлэх
- Сайнцагаан, Баянжаргалан, Дэлгэрхангай, Дэрэн зэрэг сумдад сургуулийн, Өндөршил, Дэлгэрхангай, Баянжаргалан зэрэг сумдад цэцэрлэгийн, Сайхан-овоо, Дэлгэрцогт зэрэг сумдад соёлын төвийн барилгыг шинээр барих
- Боловсролын байгууллагуудыг хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон, орчны стандартын шаардлага хангасан ширээ, сандал бусад эд хогшлоор хангах
- Аймгийн төвийн сургуулиудын үйл ажиллагааг өргөжүүлж 2-3 цогцолбор сургууль байгуулж ажиллуулах
- Боловсролыг санхүүжүүлэх, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын нийгмийн баталгааг хангахад снцгой ансаарах
- Иргэдэд тасралтгүй боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх
- Боловсролд хандах эцэг, эх, байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлж, сургуульд бэлтгэх ажлыг өргөжүүлэх, өөрчлөх, олон хувилбарт арга хэлбэрийг туршин нэвтрүүлэх
- Зуны болон гэр цэцэрлэг, ээлжийн бүлэг зэрэг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтын шинэ хэлбэрүүдийн оновчтой хувилбаруудыг туршин нэвтрүүлэх
- Сургууль, цэцэрлэгийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр аймгийн хэмжээний сургуулиудын нэгдсэн зураглалыг гаргаж, бүсчлэн хөгжүүлнэ.
- Бүсийн төв сургуулиудын материаллаг нөхцлийг сайжруулахад түлхүү анхаарч аймгийн хэмжээнд үйлчлэх цогцолбор сургууль, бүсийн төв сургуулиудын хэв шинжийг орон нутгийн онцлог нөхцөлд тохируулан оновчтой сонгож хөгжүүлэх
- Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалттай анги, бүлэг авьяас хөгжүүлэх дугуйлан секцийн үйл ажиллагааг чанаржуулж, суралцагчдын хэрэгцээнд тохирсон боловсрол олгох хэлбэрийг өргөтгөх

- Бүх сумдад дотуур байр ажиллуулах нөхцөл бүрдүүлж, малчдын хүүхдийг сургуульд сурах боломжоор хангах
- ЕБСургуулиудад багшлах, багшийн мэргэжил сонгох сонирхолтой сурагчдыг эртнээс илрүүлэн сонгон суралцах секц дугуйлангаар бэлтгэн хөдөө орон нутагт нэн дутагдалтай байгаа багшийн мэргэжлээр элсэлтийн төлөвлөгөөг нэмэгдүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бий болгох
- Нэн шаардлагатай мэргэжлээр багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн зохих болзол хангаж байгаа тодорхой тооны оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх, орон нутагт гэрээгээр ажиллуулах арга хэмжээ авах
- Сургалт арга зүйн чиглэлээр багш нарын мэргэжил дээшлүүлэх /говийн аймаг дундын, бүсийн/ төвийг байгуулах, Боловсрол соёлын газрын үйл ажиллагааг чанаржуулж, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- Хичээлүүдийг мэргэжилтэй багш нараар заалгах боломжийг нэмэгдүүлэх үүднээс хөрвөх чадвартай багш нарыг бэлтгэх ажлыг судалж хэрэгжүүлэх
- Багш нарын сургалтын шинэ арга барилыг бүтээлчээр хэрэгжүүлэх, сурах бичиг зохиох, эрдэм шинжилгээ болон судалгааны ажил бичих, ном гарын авлага шинээр боловсруулах ажлыг урамшуулан дэмжих
- Сургалтын агуулга арга зүй, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлыг бүсчилэн зохион байгуулна. Хөгжүүлэх сургалтын арга зүйг багш нарын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд зайны сургалтын хэлбэрийг өргөн ашиглах
- Бүх сумдад "Технологи, арга зүй, сургалт мэдээллийн төв" -ийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Судалгаагаар нарийвчлан гаргасан хэрэгцээнд үндэслэн албан бус боловсрол олгох үйл ажиллагааны цаашдын чиг хандлагыг төлөвлөдөг тогтолцоог бүрдүүлэх
- Албан бус арга замаар бичиг үсгийн болон анхан, суурь боловсрол олгох дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж, боловсрол эзэмшээгүй иргэдэд зохих шатны боловсролыг нөхөн олгох
- Аймгийн төвд тахир, дутуу хүүхэд сургах, сувилах цэцэрлэг ажиллуулж, тусгай хэрэгцээт боловсролыг хөгжүүлэх
- Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах тогтолцоо бий болгох
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн мэргэжил олгох чиглэлийг иргэдийн хэрэгцээнд уялдуулан уян хатан болгож , сургалтыг нээлттэй болгож.орон нутгийн эрэлт, оюуны чадавхид зохицсон мэргэшилтэй ажиллах хүчнийг олноор бэлтгэх
- Сургууль, цэцэрлэгийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр аймгийн хэмжээний сургуулиудын нэгдсэн зураглалыг гаргаж, бүсчлэн хөгжүүлнэ.
- Бүсийн төв сургуулиудын материаллаг нөхцлийг сайжруулахад түлхүү анхаарч аймгийн хэмжээнд үйлчлэх цогцолбор сургууль, бүсийн төв сургуулиудын хэв шинжийг орон нутгийн онцлог нөхцөлд тохируулан оновчтой сонгож хөгжүүлэх

- Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалттай анги, бүлэг авьяас хөгжүүлэх дугуйлан секцийн үйл ажиллагааг чанаржуулж, суралцагчдын хэрэгцээнд тохирсон боловсрол олгох хэлбэрийг өргөтгөх
- Бүх сумдад дотуур байр ажиллуулах нөхцөл бүрдүүлж, малчдын хүүхдийг сургуульд сурах боломжоор хангах
- ЕБСургуулиудад багшлах, багшийн мэргэжил сонгох сонирхолтой сурагчдыг эртнээс илрүүлэн сонгон суралцах секц дугуйлангаар бэлтгэн хөдөө орон нутагт нэн дутагдалтай байгаа багшийн мэргэжлээр элсэлтийн төлөвлөгөөг нэмэгдүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бий болгох
- Нэн шаардлагатай мэргэжлээр багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн зохих болзол хангаж байгаа тодорхой тооны оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх, орон нутагт гэрээгээр ажиллуулах арга хэмжээ авах
- Сургалт арга зүйн чиглэлээр багш нарын мэргэжил дээшлүүлэх /говийн аймаг дундын, бүсийн/ төвийг байгуулах, Боловсрол соёлын газрын үйл ажиллагааг чанаржуулж, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- Хичээлүүдийг мэргэжилтэй багш нараар заалгах боломжийг нэмэгдүүлэх үүднээс хөрвөх чадвартай багш нарыг бэлтгэх ажлыг судалж хэрэгжүүлэх
- Багш нарын сургалтын шинэ арга барилыг бүтээлчээр хэрэгжүүлэх, сурах бичиг зохиох, эрдэм шинжилгээ болон судалгааны ажил бичих, ном гарын авлага шинээр боловсруулах ажлыг урамшуулан дэмжих
- Сургалтын агуулга арга зүй, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлыг бүсчилэн зохион байгуулна. Хөгжүүлэх сургалтын арга зүйг багш нарын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд зайны сургалтын хэлбэрийг өргөн ашиглах
- Бүх сумдад "Технологи, арга зүй, сургалт мэдээллийн төв" -ийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Судалгаагаар нарийвчлан гаргасан хэрэгцээнд үндэслэн албан бус боловсрол олгох үйл ажиллагааны цаашдын чиг хандлагыг төлөвлөдөг тогтолцоог бүрдүүлэх
- Албан бус арга замаар бичиг үсгийн болон анхан, суурь боловсрол олгох дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж, боловсрол эзэмшээгүй иргэдэд зохих шатны боловсролыг нөхөн олгох
- Аймгийн төвд тахир, дутуу хүүхэд сургах, сувилах цэцэрлэг ажиллуулж, тусгай хэрэгцээт боловсролыг хөгжүүлэх
- Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах тогтолцоо бий болгох
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн мэргэжил олгох чиглэлийг иргэдийн хэрэгцээнд уялдуулан уян хатан болгож , сургалтыг нээлттэй болгож.орон нутгийн эрэлт, оюуны чадавхид зохицсон мэргэшилтэй ажиллах хүчнийг олноор бэлтгэх
- "Мандах-бүртгэл" дээд сургуулийн салбарын элсэлт, сургалт мэргэжлийн чиглэлийг орон нутгийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхой хугацаагаар өөрчлөн ажиллуулах
- Иргэд өсвөр үеийнхэнд ардын уламжлалт урлагийг өвлүүлэх ялангуяа уртын дуу ,морин хуурыг нийтийн хүртээл болгох, нүүдлийн уламжлал, суурин

соёлын ололтыг хослон хөгжүүлэх, урлагийн төрөл бүрийн уралдаан наадмуудыг зохион байгуулж соёл урлагийн алдартнуудын эгнээг өргөжүүлэх, түүх утга соёлын өвийг хадгалан хамгаалж сан хөмрөгийг баяжуулахад чиглэгдсэн санал санаачилгыг бүх талаар дэмжиж хэрэгжүүлэх

- Аймгийн театрт өөрийн нутгийн онцлогт тохируулан төв халхын үндэсний дуулалт жүжгийн хүрээлэн гэсэн бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийх
- Аймгийн Музейн үзмэрийг баяжуулж сургалт танин мэдэхүйн төв болгон сумдын орон нутгийн судлах танхимыг шинээр тохижуулж, их говийн байгалийн ховор нандин үзмэр , хүн ардын орчин ахуйдаа зохицон амьдарч ирсэн өвөрмөц ёс заншлыг сурталчлах
- Аймгийн төв Номын сангийн номын фондын шинэчлэл хийж, номын санг мэдээлэл сурталчилгааны төв болгох ТСДЗ-ийг аймаг, сумын хамгаалалтанд бүрэн авч аялал жуулчлалыг хөгжүүлэн нийтийн хүртээл болгох
- Соёл урлагийн ажилтнуудыг орон нутагтаа бэлтгэж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах зорилгоор соёл урлагийн салбар сургуулийг аймаг, нээн ажиллуулах
- Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудын ангилал, байршлыг оновчтой тогтоож, соёлын төвүүдийг сум дунд үйлчлэх зориулалтаар шинэчлэн байгуулах
- Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож зарим соёлын байгууллагыг хувийн хэвшилд шилжүүлэх
- Аймгаас төрсөн урлагийн мастерууд, нэрт зохиолч, яруу найрагч, зураач урчууд болон орон нутгийн залуу уран бүтээлчдийн хамтарсан уулзалт цэнгүүн, тайлан үзэсгэлэнг зохион байгуулж залгамж холбоог бэхжүүлэх
- Гадаадын соёл урлагийн салбартай мэргэжлийн чиглэлээр холбоо тогтоон ажиллах, үүнд багш, уран бүтээлчдийг харилцан солилцох , соёл урлагийн ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллах

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Одоогийн байдал:

Нийгмийн даатгал нь сангийн орлогын 26,8 хувийг ажил олгогчоос, 8,3 хувийг даатгуулагчаас төлсөн шимтгэлээр, 64,6 хувийг улсын төвлөрсөн сангаас, 0,3 хувийг бусад орлогын эх үүсвэрээс бүрдүүлж байна.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй 5890 хүний 50,7 хувь нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар, 49,3 нь 1995 оноос өмнөх тэтгэврийн хуулиар тэтгэвэр тогтоолгосон иргэд байна.Тэтгэвэр авагчдын тоо жилд дунджаар 370 орчим хүнээр нэмэгдэж байна.

Улсын бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж сүүлийн 3жил дараалан шимтгэлийн орлогын төлөвлөгөө 108,5-110,3 хувиар биелж байгаа ба харин сайн дурын даатгуулагчдын хамрах хүрээ

хангалтгүй байна. Одоогийн тэтгэвэр бодох арга нь төлсөн шимтгэлтэйгээ хамааралгүйгээр хуваарилах, хувь хүний тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах болон өсгөж арвижуулах механизм үгүй зэрэг дутагдал байна.

1997 онтой харьцуулахад халамжийн төвлөрсөн төсвийн хөрөнгө 66,7 хувиар нийгмийн халамжинд хамрагдах хүмүүсийн тоо 25,6 хувиар тус тус өсч нийгмийн халамжийн төрөл, хүртээмж жил бүр өргөжиж нэг хүнд ногдох хөрөнгийн хэмжээ өссөн байна. Мөн түүнчлэн нэн ядуу өрхийн тоо 35,0 хувь, хүн амын тоо 36,7 хувь, нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан тахир дутуу иргэдийн тоо 32,0 хувиар, хүүхэд асарсны тэтгэмж авагчдын тоо 44,0 хувиар, 16 насанд хүрсэн төрөлхийн тахир дутуу иргэн, 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хөдөлмөрийн чадвараа 50 буюу түүнээс дээш хувиар алдсан хүн 6,3 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг иргэдийн тоо 20,4 хувиар тус тус нэмэгджээ.

Сүүлийн 4 жидийн байдлаар ахмад настны тоо 4200 байгаа ба 2020 онд 2 дахин өсөх хандлагатай байна. Энэ нь ахмадуудын аж байдал эрүүл мэнд, ахуй нөхцлийг сайжруулахад төр засаг, хамт олон, гэр бүлийн зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцаа, халамжийг нэмэгдүүлэх, ахмадын байгууллагын идэвх оролцоог дээшлүүлэхийг шаардаж байгаа юм.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх талаар аймгийн хэмжээнд 1997, 2002 онуудад "Ажилгүйдлийг бууруулах дэд хөтөлбөр", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр"-ийг тус тус боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг хуулийн дагуу төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс бүрдүүлж, жилдээ 40,0 гаруй сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулж байна. Аймгийн ХЭА нь нэгдсэн сүлжээ болон интернетэд холбогдон үйл ажиллагаагаа явуулж байгаа юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны хүн ам 29201 байгаагаас эдийн засгийн идэвхтэй хүн ам 23543 байна. Хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөрийн насны 3600 гаруй хүн байгаагийн 862 нь Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүд, 1627 нь албан бус секторт ажиллагсад байна. Ажилгүйдлийн түвшин 3.7 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 83.6 хувь байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 55.9 хувийг эмэгтэйчүүд, 54.2 хувийг 16-34 хүртэл насны залуучууд, 13.3 хувийг дээд болон тусгай дунд боловсролтой, 7.2 хувийг техникийн анхан шатны мэргэжилтэй хүмүүс, үлдэх хувийг бага болон огт боловсролгүй иргэд эзэлж байна. Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүдийн дундаж 295 байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд жилд дунджаар 1000 орчим хүн шинээр бүртгүүлж, 900 гаруй хүн ямар нэг шалтгаанаар бүртгэлээс хасагдаж байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлснээр иргэд, ажил олгогчдын хөдөлмөр эрхлэлтийн албанд хандах хандлага нэмэгдэж цаашдаа бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Хөдөлмөрийн насны хүн амын өсөлт хүн амын ерөнхий өсөлтөөс түрүүлж байгаа ч шинээр бий болж буй ажлын байрны өсөлт төдийлэн нэмэгдэхгүй байна. Мөн мэргэжлийн сургалтын тогтолцоо төлөвшиж чадаагүйгээс

иргэдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар сул, ажил олгогчдоос тэдэнд тавих шаадлага хэт өндөр байна.

Ажилгүйдэлд олон хүүхэдтэй, орлого багатай иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хагас бүтэн өнчин хүүхэд залуучууд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс илүү өртөж байна.

Ажилгүйдлийн гол шалтгаан нь орон нутагт шинээр бий болж буй ажлын байрны тоо хязгаарлагдмал, аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс иргэдэд хүргэх сул чөлөөтэй ажлын байрны талаар мэдээлэл, хөрөнгө оруулалтын хомсдолтой холбоотой байна.

Тус аймагт 2002 оны байдлаар 0-18 насны хүүхэд 22463 байгаагаас бүтэн өнчин 44, хагас өнчин 672, үрчлэгдсэн 17, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг 28 байна.

Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тэтгэмж болон халамж, даатгалын үйлчилгээнд хамруулах, гадаад дотоодын санхүүжилттэй хөтөлбөр төслийн хүрээнд тэдний эрх ашгийг хангахтай холбоотой олон арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлд нь хүүхдийг төлөвшүүлэх дэмжлэг туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа шаардагдаж байна.

Зорилт:

1. Нийгмийн даатгалын хуваарилалтын зарчимд үндэслэн хагас хуримтлалын буюу ажил олгогч, даатгуулагчдаас төлсөн шимтгэлээс тэтгэвэр олгодог тогтолцоонд шилжинэ.
2. Нийгмийн даатгалын хүрээг өргөтгөж, санхүүгийн бие даасан байдлыг ханган, төвлөрсөн төсвөөс хамаарах хамаарлыг арилгана.
3. Нийгмийн эмзэг бүлгийн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг боловсронгуй болгон тэдний амьдралын баталгааг хангана.
4. Хүүхэд залуучуудад хөдөлмөрийг үнэлж хүндэтгэх, амьжиргааны үндсээ гэж дээдлэх үзлийг төлөвшүүлж, мэргэжлийн сургалтын бүх хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ.
5. б.Ажилгүйдлийг бууруулах арга хэмжээний бодлого чиглэлийг орон нутгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бодлоготой нягт уялдуулна.
6. б.Ажилгүйдлийн түвшинг 1.5 хувьд, ажиллах хүчний оролцооны түвшинг 90-ээс дээш хувьд хургэнэ.
7. Хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, ТББ, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн хамтын үйл ажиллагааг уялдуулж, хөдөлмөрийн зэх зээлийн мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгоно.
8. Хүүхдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлж, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн гаралтыг бууруулан, тэднийг хүчирхийлэл дарамтаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн төлөө байгууллагын чадавхийг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих нэрийн дансны аргыг хэрэгжүүлэх, 1960 оны 1 сарын 01-ээс хойш төрсөн иргэдийн ажилласан бүх хугацаанд

төлсөн байвал зохих шимтгэлийг нэрийн дансанд шилжүүлэн тооцох аргыг хэрэглэх

- Нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөтгөж, малчид, ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд хамруулж сангийн чадавхийг нэмэгдүүлэх, улмаар хуримтлал бий болгох, чөлөөт үлдэгдлийг үнэт цаасны зах зээлд оруулах, Засгийн газрын бонд, ашигтай ажиллаж буй компанийн хувьцаа худалдан авах, арилжааны банкинд хөрөнгө хадгалуулах, өсгөх зэргээр сангийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах
- Бүсийн төвд тахир дутуу иргэдийг ажиллуулах үйлдвэр байгуулах
- Тахир дутуу иргэдийн хэрэгцээг хангах, тэдэнд боловсрол олгох, сургалт явуулах, нөхөн сэргээх төв байгуулах
- Бүсийн төвүүдэд "Ахмад настан, тахир дутуу иргэдийг сувилах сувилал" ажиллуулж, нийгэм хамт олонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хөгжүүлэх
- Ахмадуудын орон сууц, амьдрах орчин нөхцөл бололцоог дээшлүүлэх
- Ахмад настны эрүүл мэнд, аж байдлыг сайжруулахад анхаарч эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хүргэх, амралт сувилалд өргөн хамруулах
- Ахмадуудад зориулсан соёл үйлчилгээний төвийг Мандалговь хотод байгуулж ажиллуулах
- Орон нутагт Нийгмийн хамгааллын цогцолбор төв байгуулан материаллаг баазаар хангах, шилэн кабельд холбож өндөр хэмжээний хүчин чадал, хурдаар мэдээлэл солилцох.
- Орон нутгийн Нийгмийн хамгааллын төвийн дэргэд хөдөлмөрийн зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ, мэдээллийн асуудал хариуцсан тусгай албатай болох
- Ажилгүйдлийн ихэнх хувийг эзэлдэг Эрдэнэдалай, Говь-Угтаал, Сайнцагаан зэрэг сумдын Хөдөлмөр эрхлэлтийн албыг боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, шинээр бий болсон болон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг байгууллага, аж ахуйн нэгжүүд хоорондоо болон ХЭА-дтай улсын хэмжээнд интернетээр дамжуулах
- Орон нутгийн хөгжлийн төвд улсын хэмжээний загвар түшиц болсон сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах
- Бүсийн төвүүд болон сумдад нийтийн ахуйн үйлчилгээний салбарыг хувийн хэвшилд тулгуурлан бий болгох үүднээс үсчин, оёдолчин, гуталчин, дархан зэрэг чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх сургалтыг бодлого, чиглэлтэйгээр зохион байгуулж явуулах
- Өргөн хэрэглээний бараа, материал үйлдвэрлэх чиглэлээр жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээл олгох
- Өндөр хөгжилтэй орнууд болон дотоодод нийгмийн хамгааллын салбарын боловсон хүчинг бэлтгэж, чадваржуулах, ажиллах орчин нөхцөл, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх
- Ажилгүйчүүдийг хамт олны хэлбэрээр зохион байгуулалтанд оруулж, тэднээр захиалгат ажлыг гүйцэтгүүлэх замаар орлого олдог тогтолцоонд шилжих

- Бүсийн төвүүдэд цөлжилтээс сэргийлэх зорилгоор ойн зурвас байгуулах, бэлчээр, байгал экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээх зэрэг ажилд ажилгүй иргэдийг тогтмол оролцуулах
- Бүсийн төвүүдэд банк болон банк бус санхүүгийн байгууллагуудыг бий болгож өрсөлдүүлэх замаар иргэн аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх
- Иргэдийг ажлын бүрэн бус долоо хоног, богиносгосон цагаар болон гэрээр, гэрээгээр ажиллуулах хэлбэрийг нэвтрүүлэх
- Хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, тэтгэмж, даатгалын сангийн эх үүсвэрийг орон нутгийн мэдэлд дэс дараатай шилжүүлэх замаар нийгэм, хамт олны хүч нөөцөд тулгуурлан хүн амын ажилгүйдэл, ядуурал, нийгмийн хамгааллын асуудлыг бүлэг суурингууд тухайн бүс дотроо бие даан шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх
- Орон нутгийн чанартай зам засварлах, цэвэрлэх, арчлах ба мянганы зам төслийн хүрээнд түр болон байнгын ажлын байр бий болгох
- Нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Хүүхдийн төлөө төвийн дэргэд гэр бүл болон өсвөр үеийнхэнд зөвлөлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх төв байгуулах
- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албатай болох
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх сургалт сурталчилгааг тогтмолжуулж, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, хамгаалах байртай болгох
- Хүүхдийн төлөө төвийг гэр бүл хүүхдийн нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдээр хангаж, тоног төхөөрөмж материаллаг баазаар бэхжүүлэх
- Хүүхдийн хөгжих, зөв хүмүүжих орчин, нөхцлийг бүрдүүлж, Хүүхэд залуучуудын ордныг "Хүүхдийн хөгжлийн төв" болгох

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Одоогийн байдал:

Аймгийн эдийн засгийн суурь салбар нь уламжлалт мал аж ахуй байсаар байна. 2000 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 41,9 хувийг ХАА-н, 9,5 хувийг боловсруулах аж үйлдвэрийн, 20 хувийг боловсрол, эрүүл мэндийн, 28,6 хувийг бусад салбар эзэлж байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн жил бүр өсөлттэй байгаа нь эдийн засгийн байдал тогтворжиж байгааг илэрхийлж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилтийн эхэн үед эдийн засгийн тогтвортой өсөлт үндсэндээ алдагдаж аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл биет хэмжээгээр жил бүр буурч байсан бөгөөд сүүлийн 5 жил дутам үнийн дүнгээр 13,2-67,2 хувийн өсөлттэй байна. Өнөөгийн байдлаар аймгийн төв болон нийт сумдын 73,3 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдож цахилгааны найдвартай эх үүсвэртэй болсон нь үйлдвэрлэлийн өсөлтөд зохих хэмжээгээр нөлөөлжээ.

Эдийн засгийн бүтцэд өөрчлөлт орж аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 82,4 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 79,5 хувь нь хувийн хэвшлийн салбарт үйлдвэрлэгдэж байгаа нь цаашдын хөгжлийн үндэс болох нөхцлийг бүрүүлээд байна.

Аймгийн эдийн засгийн суурь салбар нь мал аж ахуй юм. Малын тоо толгой жил бүр өсч байсан хэдий ч 1999-2000 онд тохиолдсон байгалийн гамшгийн улмаас мал сүргээ 734,6 мянгаар хорогдуулсан нь аймгийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн. Хөдөөгийн малчид, хөдөлмөрчдийн шаргуу хөдөлмөрийн үрээр сүүлийн 2 жил дараалан мал сүргээ өсгөж 2002 оны эцэст 1475,0 мянган толгой малтай болоод байна. Малын тоо олноор хорогдсон нь эдийн засгийн байдалд хүндээр нөлөөлснөөр дотоодын нийт бүтээгдэхүүн 2000 онд буурсан.

Зах зээлийн шилжилтийн үед банк, санхүүгийн салбарт ихээхэн бэрхшээл тохиолдож байсан хэдий ч сүүлийн жилүүдэд арилжааны банкуудын үйл ажиллагаа мэдэгдэхүйц сайжирч байна. Санхүүгийн салбарыг бодит эдийн засагт нөлөөлөхүйц чадвар бүхий салбар болгож хөгжүүлэхийн тулд банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэж одоо аймагт хувийн хэвшлийн арилжааны 3 банк үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн 5 жилийн судалгаагаар үзвэл банкны кассын орлого, зарлага 2,2-2,3 дахин өсч, нийт зээлийн өрийн үлдэгдэл 7,9 дахин нэмэгдсэн байхад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 92 хувиар буурчээ. Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувийн жин 2002 оны байдлаар 0,62 хувьтай байна.

Санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх, төлбөрийн чадвараа нэмэгдүүлэх, иргэдийн банкинд итгэх итгэлийг сэргээх талаар банкууд онцгой анхаарч ажилласны дүнд иргэдийн хувийн хадгаламж жил бүр өсч 1998 оноос 1,9 дахин нэмэгдсэн нь ард түмний амьдралын түвшин дээшилж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийн эх үүсвэр нэмэгдэж байгааг харуулж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд хөгжлийнхөө эхний шатанд байна.

Харин үйлдвэрлэл эрхлэгчид урт хугацаатай зээл авах бололцоо орон нутагт сайнгүй байна.

Боловсон хүчин орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл өнөөгийн шаардлагыг хангахгүй байгаа, байгалийн гамшгийн улмаас малчдын нилээд хэсэг цөөн малтай буюу малгүй болсноос шалтгаалан хүн ам томоохон хот суурин газар уруу шилжих явдал үргэлжилсээр байна. Судалгаагаар манай аймгаас өөр аймаг хотод шилжигсдийн тоо жилээс жилд өсч байгаагаас үүнээс үүдэн аймгийн хүн амын тоо буурах хандлагатай байна. Энэ нь цаашдаа эдийн засгийн хөгжилд ч сөргөөр нөлөөлөх талтай.

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд төрөөс явуулж буй санхүү, төсвийн шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, төсвийн удирдлагыг боловсронгуй болгох, бүртгэл, тайлан, хяналтын тогтолцоог сайжруулах, төсвийн эрх захирагч нарын сахилга хариуцлагыг өндөржүүлэх талаар багагүй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Статистик мэдээгээр үзвэл орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж байгаа бөгөөд 2002 онд орлогын дүн 1148,5 мянган төгрөгт хүрч нийт зарлагынхаа 34,7 хувийг хангаж байна. Энэ нь татварын бааз болох аж ахуйн нэгжийн тоо өсч, татвар төлөгчийн хүрээ өргөжиж байгаатай холбоотой юм.

Одоо тус аймагт 243 аж ахуйн нэгж, 10,8 мянган иргэн, 134 төсөвт байгууллага, 20 гаруй төрийн бус байгууллага улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна. Нэг хүн амд ногдох зарлагын хэмжээ 1998 онтой харьцуулбал 53,1 хувиар өсч 64,0 мянган төгрөгт хүрсэн нь ард иргэдэд төрийн

үйлчилгээ хүргэх боломж дээшилснийг харуулж байна.Төрийн үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцлийг боломжит түвшинд бүрдүүлсэн бөгөөд сүүлийн 2 жил дараалан төсвийн өргүй ажиллав.

2002 оны байдлаар төсвийн нийт зарлага 3573,6 сая төгрөгболсон ба түүний 18,8 хувийг удирдлагын зардалд, 64,9 хувийг нийгмийн үйлчилгээнд, 16,3 хувийг эдийн засгийн бусад салбарт зарцуулж байна.Нийгмийн үйлчилгээний салбарт зарцуулсан зарлагын 56,6 хувийг боловсролд, 35,3 хувийгэрүүл мэндийн үйлчилгээнд, 8,1 хувийг бусад салбарт тус тус зарцуулж байна.Эндээс үзвэл иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээнд түлхүү анхаарал хандуулж байгаа нь харагдаж байна.

Төсөвт зарлагын 96,8 хувийг урсгал зардалд, 3,2 хувийг хөрөнгийн зардалд зарцуулж байгаа нь зарсан хөрөнгийнхөө дөнгөж 3,2 хувийг үлдэх хөрөнгө бэлтгэхэд зарцуулж, бусдыг өдөр дутмын идэвхгүй урсгал хэрэглээнд зарцуулжээ гэсэн үг.Хөрөнгийн зардлын өсөлт, бууралт нилээд хэлбэлзэлтэй байгаа нь тухайн жилийн хөгжлийн бодлого чиглэлтэй холбоотой байна. Төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2000 оны байдлаар 42,9 хувь байгаа нь улсын дунджаас 1,8 хувиар өндөр байна.

Зорилго:

Эдийн засгийн бий болсон чадавхиа зохистой ашиглах, зах зээлийн харилцаа, бүсчилсэн хөгжил, төрийн зохицуулалтын бодлогыг оновчтой хэрэглэж үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, хүн амын хэрэглээгхангах, хувийн хэвшилд түшиглэсэн бизнесийн орчин нөхцөл нь бүрдсэн эдийн засгийн бүтэц бий болгох замаар хөгжлийгтогтворжуулах үндсэн дээр харьцангуй бие даасан эдийн засагтай аймаг болоход гол зорилго оршино.

Нэгдүгээр үе шатанд эдийн засгийг харьцангуй тогтворжуулан цаашдын өсөлтийн хандлагыг бий болгоно.Энэ үе шатанд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.Үүнд:

- Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон уул уурхай, барилгын материал, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ.
- Аливаа хөрөнгө нөөцийг аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд байршуулах бодлого баримтална.
- Хувийн секторын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах бодлого баримтална.
- Төрийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх явдлыг өргөжүүлэх замаар үйл ажиллагааг нь дэмжинэ.
- Гөлтгөнө, эрдсийн будаг, цагаан тугалга, жонш, төмрийн ордуудыг бүрэн ашиглана.
- Шинэ дэвшилт технологи ашиглан мал аж ахуйн түүхий эд мах, сүү, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж үр ашигтай ажиллуулан өөрийн хэрэгцээг хангана.
- Гүүний айраг, ингэний хоормог боловсруулалтаар төвийн бүсэд тэргүүлэх чиглэл баримтална.
- Амралт сувилал, спорт-аялал, ардын урлаг/уртын дуу/, нүүдлийн уламжлал, суурин соёлын ололтыг хослон сурталчлах чиглэлээр аялал, жуулчлалыг хөгжүүлэн, дэд бүтцийн гол салбарын нэг болгоно.

- Байгаль орчин-эдийн засгийн хөгжлийн оновчтой харьцааг бүрдүүлснээр байгалийн нөөц баялгийг боломжит хэмжээнд нь зохистойгоор ашиглах, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх нөхцлийг хангана.
- Байгаль орчныг хамгаалах, ашиглах ажлыг зохицуулахад эдийн засгийн хөшүүргүүдийг өргөнөөр хэрэглэнэ.
- Зах зээлийн зарчимд тулгуурласан санхүүгийн систем бүрдүүлнэ.
- Санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх үүднээс нягтлан бодох бүртгэлийн найдвартай тогтолцоог хэрэгжүүлнэ.
- Хөдөө орон нутагт төлбөр тооцоо, банкны үйлчилгээг үр ашигтай хүргэх төрөл бүрийн сувагтай болж санхүүгийн суурь үйлчилгээ үзүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ./ Банк бус санхүүгийн байгууллага, бүс нутгийн хоршоодууд, хувийн банк г.м/
- Алслагдсан орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлж, ажлын байр бий болгоход хөрөнгө оруулалт хийсэн иргэд, хуулийн этгээд, үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхлэхээр байгуулагдсан аж ахуйн нэгжид албан татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх замаар аж ахуйн нэгжийг нэмэгдүүлж, татварын бааз суурийг өргөжүүлнэ.
- Говийн бүсэд ажлын үр ашигтай байр, бизнесийн ирээдүйтэй төрөл, чиглэлийг бий болгох үйл ажиллагааг "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаас урамшуулах тогтолцоонд шилжинэ.
- Нар, салхины эрчим хүч ашиглах, түлш бэлтгэх, ус зөөвөрлөх, цэнгэгжүүлэх, холбоо, мэдээлэл түгээх авсаархан тоног төхөөрөмжийг айл өрхийн амьдралд өргөн нэвтрүүлнэ.
- Малын тэжээл, ундны усны нөөцөөр хангахад шаардагдах төсөвт зардлыг нэмэгдүүлнэ.
- Усалгаатай нөхцөлд олон наст ургамал тариалж, тэжээлийн баазтай болох чиглэл баримтална.
- Сумдыг бүсчлэн бүсийн төвүүдийн үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлнэ.
- "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хүрээнд Япон улсын тусламжаар хэрэгжүүлэх мэдээллийн систем бүрдүүлэх төсөлд хамрагдана.
- "Монгол даатгал" компаний аймаг дахь салбарыг хувьчлах.
- Сайн дурын даатгалын төрлийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, даатгалын хүрээг өргөтгөж, нэр төрлийг нэмэгдүүлэх
- Даатгалын статистик бий болгох, заавал болон сайн дураар даатгуулах даатгалын хураамжийн хувь тогтоолтын байдалд судалгаа хийж өөрчлөх

Хоёрдугаар үе шатанд эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана.Энэ үе шатанд дараах гол зорилтыг хэрэгжүүлнэ.Үүнд:

- Хадгаламж болон хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангах банк бус санхүүгийн байгууллагын тоог нэмэгдүүлнэ.
- Банкны бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслэлүүдийг нэвтрүүлнэ.
- Оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
- Экспорт, хэрэглээний бараанд баримжаалсан үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Нийгмийн салбарын хувьчлалыг оновчтой зохион байгуулах замаар бүтцийн өөрчлөлт хийж, орон нутгийн өмчийн хувьчлалыг гүнзгийрүүлнэ.

- Аймгийн эдийн засгийн хөгжилд стратегийн ач холбогдол бүхий уран, алт, үнэт чулууны ордуудыг бүрэн ашиглана.
- Нүүрсний боловсруулалттай дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи нэвтрүүлнэ.
- Анхан шатны болон эцсийн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг экспортод гаргах чиглэл баримтлан экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Хадгалалт сайтай, хүнсний шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Бүс нутгийг эдийн засгийн талаар бие даалгах бодлого баримталж, бүсүүдийн хөгжлийн түвшинг дээшлүүлж, нутаг дэвсгэрийн харьцангуй жигд хөгжлийг хангана.
- Бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжин урамшуулна.
- Мэдээллийн орчин үеийн технологийг бүх салбарт нэвтрүүлнэ.
- Улсын авто болон төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдоно.
- Бүсүүдийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтуудыг шийдвэрлэхэд сумдын хамтын ажиллагааг өргөжүүлж улмаар бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдуулан засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох чиглэл баримтална.
- Бүх салбарын хоршооны хөдөлгөөнийг дэмжин хөгжлийг нь эрчимжүүлж, хоршиж хамтран ажиллах чиглэлээр дундын хоршоог хөгжүүлнэ.

Эдийн засгийн салбарын хамрах хүрээ:

1. Хөдөө аж ахуй
2. Аж үйлдвэр
3. Худалдаа
4. Ахуйн үйлчилгээ
5. Зам тээвэр
6. Мэдээлэл, холбооны технологи
7. Эрчим хүчний хангамж
8. Аялал жуулчлал
9. Гадаад харилцаа

ХӨДӨӨ АЖ АХУЙ Хамрах хүрээ:

1. Мал аж ахуйн бодлого
2. Мал эмнэлгийн үйлчилгээ
3. Мал үржлийн бодлого
4. Бэлчээрийн тогтвортой менежментийг сайжруулах
5. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах
6. Газар тариалан хөгжүүлэх
7. Гахай, шувууны аж ахуйг хөгжүүлэх

Мал аж ахуйн бодлого

Одоогийн байдал:

Монгол улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа Малын эрүүл мэндийг хамгаалах, Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах, Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах, Шилмэл хээлтүүлэгч хөтөлбөрүүд болон эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан,

аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн чиглэл, төлөвлөгөөнд тодорхой асуудлыг тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн эдийн засгийн суурь салбар нь мал аж ахуй юм. Тус аймгийн мал сүрэг 1999 онд 2.1 саяд хүрсэн боловч 1999-2000 оны ган, зудад нийт малын гуравны нэг нь хорогдож 1.2 сая малтай болсон юм. Харин сүүлийн 2 жилд малын тоо толгой өсч 2002 оны эцэст 1474.9 мянган мал үүний дотор тэмээ 19.7, адуу 113.4, үхэр 32.6, хонь 685.5, ямаа 623.6 мянгыг тус тус тоолуулж, өмнөх оноос бүх малаа 5 төрөл дээр нь 5.6 хувиар буюу 77.6 мянгаар өсгөсний 93.6 хувь нь буюу 72.7 мянга нь ямаа байна.

Аймгийн мал сүргийг 2002 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтээр харууллаа.

№	Сумын нэр	Бүгд	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1.	Дэлгэрцогт	80529	375	6281	2727	36031	35115
2.	Дэрэн	111963	966	10085	3020	55018	42874
3.	Говь-Угтаал	91615	423	7901	1567	43743	37981
4.	Цагаандэлгэр	42967	533	5706	615	17769	18344
5.	Баянжаргалан	60458	214	4933	2028	28300	24983
6.	Өндөршил	59066	1052	6348	2111	27144	22411
7.	Гурвансайхан	119127	1324	7628	2174	58277	49724
8.	Өлзийт	130411	5981	8871	908	52549	62102
9.	Хулд	88873	2157	6674	543	39925	39574
10	Луус	97954	441	8552	1863	49840	37258
11	Дэлгэрхангай	67352	2503	3456	689	23661	37043
12	Сайхан-Овоо	78647	1039	4293	764	34288	38263
13	Эрдэнэдалай	191749	1181	12229	6972	98865	72502
14	Сайнцагаан	158431	982	12275	2992	74128	68054
15	Адаацаг	95854	556	18177	3681	46013	37427
	ДҮН	1474996	19727	123409	32654	685551	623655

Тус аймагт нэг өрхөд 157.2, нэг малчин өрхөд 183.4 мал, нэг хүнд 28.7 мал, үүнээс тэмээ 0.3, адуу 2.2, үхэр 0.6, хонь 13.3, ямаа 12.1 тус тус ногдож байна.

Аймгийн хэмжээнд амины малтай 9377 өрх байгаагаас /үүнээс жилийн 4 улиралд байнгын мал малладаг 8040 малчин өрх байна/. 10 хүртэл малтай 264, 11-30 малтай 893, 31-50 малтай 1070, 51-100 малтай 2246, 101-200 малтай 2510, 201-500 малтай 2042, 501-999 малтай 322, 1000-1499 малтай 26, 1500-аас дээш малтай 4 өрх байна. Нийт малтай өрхийн 47.7 хувь нь 100 хүртэл толгой малтай буюу нэн ядуу, ядуу өрхөд, 26.7 хувь нь 100-200 толгой малтай ядуу өрхөд хамаарах байдалтай байна.

Малын чанар үржлийн ажлыг сайжруулах, Малын эрүүл мэнд, Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд нутгийн өндөр ашиг шимт малыг өсгөх, малын халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвс, тэжээл, ус хангамж, хашаа хорооны хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

Аймагт улсын нөөцийн өвс тэжээлээс гадна, аймгийн өвс тэжээлийн нөөцийг аймгийн төв, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдад төвлөрүүлж, сумд өөрийн нөөцтэй болсон.

Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй болон энгийн 3624 худаг байна. Нийт худгийн 25.4 хувь буюу 744 худаг ашиглагдахгүй байгаа нь хүн малын усан хангамжид муугаар нөлөөлж байна.

Нийт бэлчээрийн 28.6 хувь нь /1345.0 мян/га/ ашиглагдахгүй байгаагийн 63.7 хувь нь зөвхөн усгүйгээс болж байна. Энэ нь уст цэгийг засварлах шинэчлэх усны хайгуул хийхийг шаардаж байна.

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 98.7 хувь буюу 73.8 мянган га нь бэлчээр бөгөөд 2000 онд мэргэжлийн байгууллагаас хийсэн бэлчээрийн даацын судалгаа, бэлчээрийн төлөв байдал хянан баталгаанаас үзэхэд бэлчээрийн ургамлын хэмжээ 1962-1992 онд /30 жилд/ 46.3 хувь буурсан бол 1992-2000 онд /8 жилд/ 30 хувь буурсан нь тус аймагт байгаль цаг агаарын таагүй нөхцөл ойр ойрхон тохиолдсоноос шалтгаалж цөлжилт эрчимжиж, ургац буурч бэлчээрийн хомсдолд орох болсныг харуулж байна.

Дээрх нөхцөл байдлаас гадна сүүлийн жилүүдэд хойд болон төвийн 9 сумын 1200,0-1500.0 мян.га бэлчээрт үлийн цагаан оготно тархаж, хэдэн жил дараалан хур бороо бага орж ган болсон, бэлчээрийн ус хангамж хомсодсон зэргээс шалтгаалж ихэнх суманд бэлчээрийн даац одоо байгаа малыг хонин толгойд шилжүүлж тооцоход хэтрэх хэмжээнд хүрсэн.

Зорилт:

Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон эрчимжүүлж, малыг даатгалд хамруулж, мал эрүүлжүүлэх, чанарыг сайжруулах, ус, бэлчээр, өвс, тэжээлийн хангамжийг сайжруулах замаар зүй бусын хорогдлыг багасган, мал сүргийн өсөлтийг хангаж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, малчдын аж амьдралыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгож, малчдыг зах зээлийн нөхцөлд үйлдвэрлэлээ үр ашигтай эрхлэх арга ухаанд сургах замаар тэдний аж амьдралаа дээшлүүлэхэд нь туслах
- Малчдыг малжуулах арга хэмжээг Дэлхийн банкны урт хугацааны зээлийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх
- Малыг байгалийн гамшиг, эрсдэлээс хамгаалахын тулд гадаад орны зээл, тусламж, төслийн хөрөнгөөр мал хамгаалах санг аймаг, суманд бий болгон ашиглах
- Малчдын хөдөлмөрөө хорших, хоршоо байгуулах санаачлагыг дэмжих
- Тэмээ өсгөх талаар тусгай бодлого боловсруулж хэрэгжүүлэх, тэмээг ачлага эдэлгээ, сүү, ноосны, адууг уналга-эдэлгээ, махны, үхрийг мах, сүүний, хонийг мах, ноосны, ямааг ноолуур, сүүний чиглэлээр, бод малыг түлхүү өсгөх бодлого баримтлах

- Малчдын малаа өсгөх санаачлагыг дэмжиж, малын зүй бусын хорогдлыг багасган, аймаг, бүсийн төвүүдэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эхлэл тавих

Мал эмнэлгийн үйлчилгээ

Одоогийн байдал:

Аймгийн Мал эмнэлгийн тогтолцоо ХХААГ-ын Мал эмнэлгийн алба, мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори, сумдад хувийн мал эмнэлгийн нэгжүүд гэсэн бүтэцтэй байна.

Мал эмнэлгийн алба болон мал эмнэлгийн ариун цэврийн лабораторит 6 их эмч, 2 бага эмч, сумдын 19 хувийн МЭ-т их эмч 24, бага эмч 14 ажиллаж байна.

Дээрх бүтэц орон тоогоор жилдээ 700-800,0 мянган толгой малыг халдварт өвчнөөс, 1000-1200,0 мянган толгой малыг паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, 400-500,0 мянган толгой малд лабораторийн шинжилгээ, 270-300,0 тн мах, 240-250,0 мянган ширхэг арьс шир, 100-120,0 тн ноолуурт мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, 200-320,0 мянган м.кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна.

Тус аймагт дуут хавдар, шөвөг яр, сахуу, сохор догол, дотрын халдварт хордлого, энтеробактериоз зэрэг халдварт өвчнүүд, үхрийн арьсны гуур, адууны хөндийн гуур, бог малын туузан хорхойтох, ширхтэх зэрэг паразиттах өвчнүүд голчлон гардаг бөгөөд сүүлийн үед байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан бодисын солилцооны эмгэг гарах төлөвтэй байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлэхэд дараах давуу болон сул талууд байна.

Бүх сум мал эмнэлгийн нэгжтэй, их эмчээр бүрэн хангагдсан, аттестатчилалд бүрэн хамрагдаж, итгэмжлэлээ авсан, халдварт өвчний гаралтаар бусад аймгаас харьцангуй тайван, ялангуяа бруцеллёз өвчний халдварлалт улсын дунджаас доогуур, 0,1 хувийн халдварлалтай байдаг.

Харин малчдад хүрч үйлчлэх үйлчилгээ хангалтгүй, зах зээлд нийлүүлж байгаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналт сул, мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн тоног төхөөрөмж хуучирсан, хувийн мал эмнэлгүүдийн эдийн засгийн хүчин чадал сайнгүй, малын удмын сан эрүүл мэндийн хууль тогтоомжийг малчдад сурталчлах, ойлгуулах ажил хангалтгүй, малын эм бэлдмэл дутагдалтай, гадаад харилцаа хөгжөөгүй зэрэг сул талууд байна.

Зорилт:

Мал сүргийг эрүүлжүүлэх, халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг олон улсын жишигт хүргэн, үр дүнг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Сумдын мал эмнэлгийн нэгжүүдийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог боловсронгуй болгох
- Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Адууны цусны паразиттах өвчинтэй тэмцэх арга хэмжээг боловсруулан уг өвчнөөс эрүүлжүүлэх, сэргийлэх арга хэмжээ авах

- Бэлчээрийн ургамал хомсдож, байгаль дахь макро, микро элементийн харьцаа алдагдаж бодисын солилцооны хямралын өвчин гарч байгаа тул Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран кальци-фосфорын харьцаа, фтор зэсийн дутагдлын эмгэгийг оношлох, тэмцэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх
- Сумдын мал эмнэлгүүдийг эдийн засгийн хувьд бүрэн биеэ даах хэмжээнд хүргэх
- Мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори зарим вакциныг орон нутагт үйлдвэрлэх, малын өвчин эмгэгийг бүрэн оношлох хэмжээнд хүрэх, бүсийн хэмжээний лаборатори болох
- Мал эмнэлгийн гадаад харилцааг сайжруулж мэргэжилтэн болон эм бэлдмэл солилцох, харилцан хөрөнгө оруулах, хамтарч ажиллах

Мал үржлийн ажил

Одоогийн байдал:

Аймгийн Мал үржлийн алба малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах 2002-2005 он хүртэл хэрэгжүүлэх хөтөлбөр, шилмэл хээлтүүлэгч дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн энэ хүрээнд 15 сумыг хамран мал үржлийн ажлыг жилийн болон хэтийн бодлого чиглэлтэйгээр хөгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2002 оны эцэст 19,4 мянган цэвэр, эрлийз мал тоологдож мал сүрэгт ангилалт, шилэлт явуулсны үр дүнд цөм сүрэгт бүртгэгдсэн 98,8 мянган эх мал байгаагаас ингэ 1,7, гүү 8,0, үнээ 4,2, эм хонь 49,3, эм ямаа 35,6 мянга, оны эхний хээлтэгчийн 13,6-29,9-ийг эзэлж байна. Цөм сүргийн нэг малаас тэмээний ноос 6827 гр, хонины ноос 1310 гр, ноолуур 369 граммыг тус тус ашиглаж байна. Одоогийн байдлаар нийт малын үүнээс хээлтүүлэгч малын ашиг шимийн дундаж дараах байдалтай байна.

Малын төрөл	Амьдын жин кг	Ноос ноолуур гр
Тэмээ/буур	459,8/573,4	5593,0/7755,0
Адуу/азарга	307,1/357,1	
Үхэр/бух	312,7/445,7	
Хонь/хуц	49,3/67,2	1182,0/1317,0
Ямаа/ухна	39,8/56,2	304,5/398,0

Дээрх судалгаанаас харахад Дундговь аймгийн удмын сангийн малын ашиг шимийг дээшлүүлж, чанарыг сайжруулж цөөн малаас арвин их бүтээгдэхүүн ашиглах боломж харагдаж байна.

Аймгийн хэмжээнд оны эхний нэг хээлтүүлэгчид ингэ 23, гүү 6, үнээ 24, эм хонь 51, эм ямаа 47 ногдож бүх хээлтүүлэгчийн 96-99,5 хувийг стандартын буюу шилмэл нэгдүгээр ангийн хээлтүүлэгч эзэлж байна.

Мал үржлийн ажлыг удирдан явуулахад дараах эерэг, сөрөг нөхцөл байдлуудыг харгалзан үзэх хэрэгтэй.

Малчид хоршин ажиллах, цөөн малаас арвин ашиг шим хүртэх сонирхбл бүрдэж, мал үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулахын ач холбогдлыг практик туршлагаараа ойлгох болсон, сүргийн чанарыг сайжруулагч хээлтүүлэгч малыг шилэн сонголтоор тавих аргад суралцаж байгаа, цөөнгүй малчид дуудлага болон үзэсгэлэн худалдаанд оролцож сүргийн чанараа сайжруулж байгаа эерэг нөлөө байвч байгаль цаг агаарын нөхцөл жил бүр хүндэрч, гамшгийн тоо ихэсч, бэлчээрийн ургамлын төрөл, ургацын хэмжээ буурч, мал үржлийн ажил эрхлэн явуулах мал зүйч, мэргэжилтний хүрэлцээ хангамж муу, малчид тархай бутархай нүүдлийн байршилтай зэрэг нь үржлийн ажлыг төвлөрүүлж явуулахад хүндрэл учруулах сөрөг талтай юм.

Зорилт:

Мал үржлийн ажилд шинэ дэвшилтэт арга нэвтрүүлэн сүргийн бүтцийг сайжруулах замаар таван төрлийн малд цөм сүргийн эзлэх хувийг 25-35 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Эхний үе шатанд үржлийн ажилд дараах бодлого баримтална.

- Сүргийн зохистой бүтэц бий болгох, таван төрлийн малын тэнцвэрт харьцааг бүрдүүлэх, ашиг шим, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангаж, мах, ноосны хэвшлийг баримтлан шилэн сонголт хийж үржүүлэхийн зэрэгцээ Хулд сумын Олдох, Өлзийт сумын Хайрханы шилмэл буураар сайжруулах
- Адуун сүргийн уналга эдэлгээний болон нутгийн хэвшлийг тодруулах замаар хурдлах чадварыг бататгах, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өөрийн аймгийн шилмэл азаргыг сайжруулагчаар ашиглахын зэрэгцээ Төв, Хэнтий, Дорноговь аймгаас сайжруулахыг дэмжих
- Үхэр сүргийг мах, мах-сүүний чиглэлээр үржүүлж, Дорнодталын махны үхрээр сайжруулсан цөм сүргийн болон мах сүүний хосолмол ашиг шимтэй бухыг ашиглах
- Хонин сүргийг махны хэвшлээр өөр дотор нь шилэн сонгож сайжруулах, Үзэмчин, Барга, Баянцагаан омгын хуц ашиглах
- Ямаан сүргийн ноолуурын гарцыг бууруулахгүйгээр голчийг нарийсгах, цагаан цайвар болгоход анхаарч цөм сүргээсээ тавьсан шилмэл ухна ашиглан өөр дотор нь сонгон үржүүлэх бодлого баримтлах, сайжруулагчаар Баяндэлгэр, Өлгийн улаан ухна ашиглах
- Хулд, Өлзийт сумын Олдох, Хайрханы тэмээ, нутгийн адууны хэвшлийг омог болгон батлуулах, Эрдэнэдалай сумын сайжруулсан хонин сүргийг нутгийн үүлдрийн хэсгээр баталгаажуулах

Дараагийн үе шатанд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

- Шинжлэх ухааны ололтод үндэслэн үржлийн ажлын шинэ арга нэвтрүүлж сүргийн чанарыг сайжруулах бодлого баримтлах
- Мал үржлийн ажилд шилмэл хээлтүүлэгчээс гадна гүн хөлдөөсөн үр биотехнологийг нэвтрүүлж эхлэх
 - ❖ Аймгийн Мал үржлийн албаны дэргэд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарыг үнэлэх иж бүрэн тоноглогдсон лаборатори байгуулах

- ❖ Аймаг бүхэлдээ сайн чанарын цагаан ноолуур бэлтгэдэг болох
- ❖ Таван төрлийн малын үржил селекцийн ажил гардан явуулдаг 24 төв /тэмээний 2, эдууны 4, үхрийн 2, хонины 8, ямааны 8/ бий болгох
- ❖ Аймгийн төв болон бүсийн төв сумдад сүүний болон гахай, тахианы фермер байгуулах
- ❖ Мал үржлийн ажил хариуцсан хоршоог дэмжин хөгжүүлэх

Бэлчээрийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх

Одоогийн байдал:

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар аймгийн нийт нутаг дэвсгэрийн 98,7 хувь буюу 7377,6 мянган га нь бэлчээр бөгөөд хадлан, газар тариалангийн чиглэлээр ашиглагдаж байгаа газар үндсэндээ байхгүй, усгүйгээс ашиглагдахгүй байгаа, талхлагдсан, элсний нүүлтэд өртсөн, мал бэлчих өвсгүй асга хад, нуурын шал, тойром бүхий газар мөн үлийн цагаан оготnod нэрвэгдсэн зэргээс 1400,0 гаруй га бэлчээр ашиглагдахгүй байгаа гэж үзвэл 5977,6 мянган га бэлчээр ашиглагдаж байгаа юм.

2001 онд газар зохион байгуулалтын "ЛАНРЕС" ХХК-аас хийсэн бэлчээрийн даацын судалгаа, бэлчээрийн төлөв байдал, хянан баталгааны материалаас үзэхэд бэлчээрийн ургац 1962-1992 онд /30 жилд/ 46.3%-иар, 2000 оныг 1992 онтой харьцуулахад /8 жилд/ 20-30%-иар буурсан, бэлчээрийн үндсэн ургамал болсон хялгана, хиаг, өрхөг, хазаар өвс, алаг өвс зэрэг ургамлын гарц багассан байна.

Тус аймагт нэг га-гийн жилийн дундач ургацыг 1,7 ц гэж тооцвол хонин толгойд шилжүүлснээр 1700,0-2200,0 мянган хонь бэлчээрлэх боломжтой бөгөөд аймгийн хэмжээнд бэлчээрийн даац ихэнх сумдад хэтэрч байна.

Аймгийн ИТХ-аас 2002 онд аймгийн бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэл баталж, Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлагын төлөөлөгчийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн газар, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн газартай хамтарч бэлчээрийн менежментийг сайжруулах, зохистой ашиглах талаар сумдын удирдлага, мал аж ахуйн мэргэжилтнүүд, малчдын дунд сургалт зохион байгуулах, бэлчээр усжуулах, үлийн цагаан оготnotой тэмцэх, бэлчээр хаших, сум дундын отрын бүс нутаг тогтоох, бэлчээрт олон наст ургамал тарих зэрэг арга хэмжээ авч байна.

Зорилт:

Бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулж, нөхөн сэргээх ажлыг шаардлагын түвшинд хийж гүйцэтгэх чадавхи бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Ашиглагдаагүй байгаа бэлчээрийг ашиглах замаар мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдүүлэх
- Үнэг, хярс агналтыг зохицуулж, экологийн тэнцвэрийг хангах
- Үлийн цагаан оготnotыг химийн аргаар устгах хэмжээг зохистой хэмжээнд барьж механик болон байгалийн аргаар устгахад илүү анхаарах
- Талхлагдсан болон талхлагдаж болзошгүй байгаа бэлчээрийг ашиглалтгүй өнжөөж байгалийн аясаар нь сэргээхийн эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг малчдад ойлгуулж, тэдний хяналт, оролцоог нэмэгдүүлэх

- Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх зориулалтын сан бий болгож зарцуулах
- Нутаг усныхаа бэлчээрийг хамгаалах нөхөн сэргээх ажилд малчин бүрийн оролцоог тодорхойлж, модлог бутлаг ургамал тариулж хөрсний шилжилтийг зогсоох, бэлчээрт олон наст ургамал ургуулах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах
- Бэлчээрийг малчдын хэсэг бүлэгт хуваарьтай ашиглуулах ажлыг тусгай болзол гэрээний дагуу зохион байгуулах
- Бэлчээрийн тоо, чанарын үнэлгээ, мониторинг хийх чадварыг орон нутагт бий болгож судалгаа шинжилгээ, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж ашиглах

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах

Одоогийн байдал:

Аймгийн хэмжээнд төв суурингийн ус хангамж болон бэлчээр усжуулалтын зориулалтаар өрөмдмөл, богино яндант, бетон хашлагат уурхайн, энгийн уурхайн гэсэн 4 төрлийн нийт 3624 худаг байгаа бөгөөд үүнээс 68 нь төв суурингийн усан хангамжийн, бусад нь бэлчээрийн зориулалттай байна.

Бэлчээрийн ус хангамж хамгийн сайн байсан 1989 онд нийт бэлчээрийн 72.5 хувь нь усжуулагдсан, бэлчээрт өрөмдмөл худаг 237, богино яндант худаг 290, бетон хашлагат уурхайн худаг 1200, энгийн уурхайн худаг 2195, усан сан 134, нийт 4056 уст цэг ашиглагдаж, бэлэн байдлын түвшин 80 хувиас дээш байлаа. Тэр үетэй харьцуулахад өрөмдмөл, богино яндант худаг, усан сан үндсэндээ бүрэн устаж, эргүүлэгтэй бетон хашлагат худаг гар татлагатай болж хөдөөгийн малын ус хангамж гар татлагатай бетон хашлагат болон энгийн гар худгаас хангагдаж ирлээ.

Харин 1997 оноос улсын төсвийн болон гадаад орны хөрөнгө оруулалтаар 120 гаруй инженерийн хийцтэй /ихэнх нь өрөмдмөл/ худаг сэргээн засварлаад байна. Усгүйгээс ашиглаж чадахгүй байгаа 11 сумын 35 томоохон бэлчээр байна. Бэлчээрийн уст цэг олноор тоногдож үрэгдсэн, сэргээн засварласан ч ашиглагдахгүй байгаа худаг олон байгаа нь худгийн ашиглалт, эзэмшилтийн тогтолцоо, менежментийн хувьд дутагдалтай, нөгөө талаас орон нутагт усны мэргэжлийн байгууллагын хүчин чадал муудсантай холбоотой юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 1999 оны 5 дугаар тогтоолоор инженерийн хийцтэй худгийг эзэмшүүлэх журмыг баталсан бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр болон бусад хөрөнгөөр сэргээн засварласан худгийг малчид, малчдын бүлэгт эзэмшүүлэх бодлого баримталж байна. Орон нутагт худгийн эзэмшилт, ашиглалт, малчдын ундны усны хүрэлцээ, усны чанар, мэргэжлийн байгууллагын хүчин чадал, тоног төхөөрөмж, мэргэжилтэй боловсон хүчний хангамж хангалтгүй байна.

Зорилт:

Бэлчээрийн ус хангамжийг 2010 онд 75%, 2020 онд 80 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Худаг уст цэгийн нарийвчилсан тооллого хийж ашиглагдахгүй байгаа худгаас засаж болох худгуудыг сонгож, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олох
- Гүний ус илрүүлэх замаар усгүй бэлчээрийг усжуулах арга хэмжээ авах

- Япон улсын буцалтгүй тусламж, улсын төсвийн оролцоотойгоор бага гүнтэй худаг сэргээх, шинээр гаргах замаар бэлчээрийн худгийн тоог нэмэгдүүлэх, гар худаг гаргасан, булаг шанд тохижуулсан иргэд, малчдыг урамшуулах тогтолцоо бий болгох
 - Бэлчээрийн нөхцөлд тохирсон гүний болон авсаархан, хямд төсөр усны насос, тоног төхөөрөмжөөр хангах
 - Бэлчээрийн худгийг өмчийнх нь хувьд тодорхой гэрээ, нөхцөл болзлын дагуу эзэнтэй болгож, ашиглалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх
 - Найдвартай уст цэгийг хувийн хэвшлийн захиалгаар гаргаж эзэмшүүлэх

Газар тариалан хөгжүүлэх

Одоогийн байдал:

Тус аймагт газар тариалан эрхэлж ирсэн түүхэн уламжлал, дадлага туршлага багатай боловч 1980-аад оны үед Сайхан-Овоо суманд Онгийн голыг түшиглүүлж 38-64,0 га-д төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал, бүх суманд булаг, өрөмдмөл худгийн ус ашиглан төмс, хүнсний ногоо тарьж байсан юм.

Монгол Улсын Засгийн газраас 1997 оноос хэрэгжүүлж эхэлсэн "Ногоон хувьсгал" хөтөлбөр, Дэлхийн зөн ОУБ-ын ОНХХ-ийн ногоожуулах төслийн хүрээнд иргэдийг төмс, ногоо тариалуулах хөдөлгөөнд хамруулснаар 2002 оны байдлаар аймгийн хэмжээнд 18 байгууллага, аж ахуйн нэгж, 1000 гаруй өрх 31.3 га-д төмс, 21 га-д хүнсний төрөл бүрийн ногоо, 1,0 га-д жимс жимсгэнэ, 0,6 га-д малын тэжээл тариалсан дүн мэдээтэй байна.

Тус аймагт хадлангийн газар байхгүйгээс гаднын аймаг сумаас өвс хадлан хадах, өвс тэжээл худалдан авах замаар малын тэжээлийн хангамжийг шийдэж ирлээ.

Тус аймагт газар тариалан түгээмэл хөгжүүлэхэд байгаль цаг агаарын хувьд тааламжтай биш, хуурай, хөрсний үржил шим муу, ус муутай, хөрөнгө, санхүүгийн хувьд хязгаарлагдмал, хамгийн гол нь иргэд энэ талаар туршлага, дадлага муутай зэрэг нь мал аж ахуй, газар тариалан хослон хөгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Гэвч цаашид бэлчээрийн мал ажахуй байгаль цаг агаарын эрсдэлд орж хүнсний хангамж хомсдож байгаа өнөөгийн нөхцөлд иргэд өөрсдийн хэрэгцээт төмс, хүнсний ногоогоо тарих, малын тэжээлийн зохих хувийг орон нутагтаа бэлтгэх шаардлага зайлшгүй болоод байна.

Зорилт:

Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхийн тулд айл өрх бүр өөрсдийн хэрэгцээт төмс, хүнсний ногоо тарих, малын тогтвортой өсөлтийг хангахын тулд малын тэжээлийн зохих хувийг орон нутагтаа бэлтгэнэ.

Хэрэгжүүлэх уйл ажиллагаа:

- Төмс, хүнсний ногоо тарьж айл өрх бүр 2010 онд өөрсдийн хэрэгцээний 30 хувь, 2020 онд 50 хувийг хангадаг болох
- Тариалангийн газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх замаар газрыг зах зээлийн эргэлтэнд оруулж ашиглалтыг сайжруулах

- Аймаг, сумдын төвд агропаркуудыг байгуулах, өргөтгөх арга хэмжээ авч эндээс газар тариалангийн талаар сургалт, сурталчилгааг байнга хийж байх
- Усалгааны дэвшилтэт арга технологи/ дуслын, нэвчилтийн, сан, хөв байгуулах/ нэвтрүүлж усалгаатай тариалан хөгжүүлэх
- Өрх болон аж ахуйн хэрэгцээнд нийцсэн бага, дунд хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжөөр хангах
- Хамгаалагдсан хөрсний /хүлэмж, нийлэг хальсан бүрхүүл гм/ таримлын хэмжээг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах замаар хөрсний шимийг хамгаалах
- Малын тэжээл бэлтгэх цех, бага оврын үйлдвэр байгуулж орон нутагт малын тэжээл үйлдвэрлэх

Гахай шувууны аж ахуйг хөгжүүлэх

Одоогийн байдал:

Хүн амын хүнсний хангамж нөөцийг нэмэгдүүлэх, таван хошуу малын зарлагыг багасгахад туслах аж ахуй буюу гахай шувууны аж ахуй чухал үүрэг гүйцэтгэнэ.

Одоо тус аймгийн Хулд, Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Цагаандэлгэр, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдад 130 гаруй гахай, 100 гаруй тахиа байна.

Тус аймгийн хувьд гахай, тахианы аж ахуй эрхлэн зохих үр дүнд хүрч байсан хүмүүс бий боловч тэр нь маш цөөн тоотой, энэ талаар уламжлал, дадлага туршлага багатай, гахай шувуу тэжээх технологи, орон байрны нөхцөл, эрүүл ахуйн талаар мэдлэг хомс юм.

Зорилт:

Аймаг, бүсийн төв сумд, бололцоотой аж ахуйн нэгжид гахай, тахианы аж ахуйг бий болгоно.

Хэрэгжүүлэх уйл ажиллагаа:

- Сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг үе шаттайгаар гахай, тахианы аж ахуй эрхлүүлэх бодлого баримталж 2010 онд сумд, аж ахуйн нэгж, байгууллагын 20-30 хувь, 2020 онд 50 хүртэл хувь нь гахай тахианы аж ахуй эрхлэх
- Сайнцагаан сумын гахай, тахиа шувууг үржлийн чиглэлээр өсгөж сумдад худалдах арга хэмжээ авах
- Гахай, тахиа, шувууны аж ахуйн ач холбогдлыг ард түмэнд ойлгуулах, радио, телевиз, сониноор дамжуулж сурталчлах

АЖ ҮЙЛДВЭР

Одоогийн байдал:

Сүүлийн 5 жилийн судалгаагаар авч үзвэл аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл жил бүр 113,2-167,2 хувийн өсөлттэй байгаа ба 2002 оныг 1998 онтой харьцуулбал 3,2 дахин нэмэгдсэн байна.

Аймгийн нутаг дэвсгэр ашигт малтмалын арвин их нөөцтэй юм.Тухайлбал: чулуун ба хүрэн нүүрс, хайлуур жонш, цагаан тугалга, цайр, гөлтгөнө, төмрийн хүдэр, занар, алт, мөнгө, уран, эрдсийн будаг зэрэг 33 нэр төрлийн ашигт малтмалын 81 орд, 149 илэрц олдож судлагдаад байна.

Бүс нутгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц Хараат, Буянтын уран, Эрээний төмрийн хүдэр, Хөөт, Их улаан нуур, Тэвш, Өвдөг худгийн нүүрс, шатдаг занар, Шар шороот, Булаг, Хөөтийн эрдэс будаг, Таргат, Ширээ уулын гөлтгөнийн болон барилгын материалын ихээхэн нөөц ордууд байна.

Эдгээрээс одоогийн байдлаар Баянжаргалан, Гурвансайхан суманд жонш, Дэлгэрхангай суманд гөлтгөнө, Тэвшийн говь, Цагаан-Овоо, Хөөтийн уурхайн нүүрсийг олборлож байна.Гэсэн ч олборлож байгаа ашигт малтмалын хэмжээ бага, олборлолт ихэвчлэн гар аргаар хийгдэж байна.

Жилд дунджаар 20 орчим мянган тонн нүүрс, 1,6 мянган тонн гөлтгөнө олборлож байна.Одоогийн байдлаар 33 аж ахуйн нэгж, 18 иргэн аймгийн нутаг дэвсгэрт ойролцоогоор 1,5 сая га талбайд 100 гаруй лиценз эзэмшиж байна.

Хайгуулын лиценз эзэмшигчдээс ашигт малтмалын эрэл хайгуул судалгааны ажил явуулж байгаа талаар орон нутгийн төр захиргааны байгууллагад мэдэгдсэн зүйлгүй байна. Цаашид хайгуулын лиценз авсан талбайд хайгуул судалгааны ажлыг хийж алт, зэс, газрын тосны ордууд илрүүлж ашиглах ирээдүй байгаа гэж тооцоолж байна.

Ураны ашиглалт нь одоогоор дэлхий нийтэд экологийн сөрөг нөлөөгүй гэж тогтоогдсон уусмалаар баяжуулах Канадын аргаар олборлох технологиор хийгдэх ба Хараат, Буянтын ордод гаднын хөрөнгө оруулалтаар хайгуул, туршилтын ажил хийгдсэн.

Ойрын ирээдүйд борлуулах зах зээл, хөрөнгийн асуудал шийдэгдвэл Баянжаргалангийн Булаг хөөт, Шар шороотын эрдэс будгийн орд, Оорцог, Бага газрын цагаан тугалга, Эрээний төмрийн орд, Хөөтийн шатах занар зэрэг ордыг ашиглах боломжтой юм. Дээрх орд газрууд нь нутгийн зүүн хэсэгт зонхилсон байршилтай, Улаанбаатар-Сайншандын чиглэлийн төмөр замаас 80-120 км зайд оршиж байдаг. Цаашид Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан Таван толгойн коксжих нүүрсний орд газрыг ашиглахтай холбогдуулан тавих төмөр замын дагуух байрлалаараа эдийн засгийн ач холбогдолтой төдийгүй дэд бүтцийн таталцлын үндэслэл болох магадлалтай юм.

Улс, бүс нутаг, аймаг. орон нутгийн эдийн засгийн хөгжилд дорвитой нөлөөлөх хөрөнгө хүч ихээхэн шаардагдах объектуудад Хараат, Буянтын ураны, Эрээний төмрийн хүдрийн, Хөөт, Их улаан нуур, Өвдөг худгийн нүүрс, шатах занар, Өлзийтийн алтны ордууд тооцогдож байна.Эрдгээр ордууд нь цар хүрээний хувьд томоохон, геологийн талаар нарийвчлан судлагдаж, заримыг нь туршилтаар ашиглаж үзсэн, улсын эдийн засаг түүний дотроос төвийн бүсийн эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц нөлөөтэй Тавантолгойн коксждог нүүрсний орд, Оюу толгойн зэсийн ордын чиглэлд тавигдах ирээдүйн төмөр замын дагуу оршдог хар металл, коксжих нүүрс, шингэн түлшний үйлдвэрлэл алс ирээдүйд хөгжих зангилаа цэгт байршиж байна.

Хөрөнгө хүч бага шаардаж түргэн хугацаанд өгөөжөө өгөх ашигт малтмалын ордод Ширээ уулын гөлтгөнө, мөн Булаг, Хөөт, Шар шороотын будаг, Бага газрын чулууны шороон ордууд орно.Булаг, Хөөтийн эрдсийн будгийн орд нь байршлаараа Хөөтийн нүүрсний ордтой зэрэгцээ оршдог, хар, хүрэн, шар зосын

орд юм.Энэ ордыг ашигласнаар эрдэс будгийн үйлдвэрийн түүхий эдийн хэрэгцээг дотооддоо хангахаас гадна Оросын холбооны улс зэрэг гадаад орнуудад хуурай зос гаргах боломжтой юм.Шар шороотын эрдсийн будгийн нөөц, чанар сайн, улаан, хүрэн, шар, цагаан өнгийн зостой бөгөөд ил аргаар гараар ашиглалт явуулан жилд 100,0 тн хүдэр олборлож, 80,0 тн хуурай будаг, 60,0 тн тосон будаг үйлдвэрлэх боломжтой.

Эрээний төмрийн хүдрийг ил аргаар олборлож Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн хэрэгцээг хангахын зэрэгцээ Хятад улсад экспортлох боломжтой.Эрээний ордын төмрийн хүдэрт хортой хольц байхгүй, байгаль орчныг бохирдуулах хор уршиггүйгээрээ давуу талтай бөгөөд Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийн орчинд хамарч байгаа юм.

Таргат, Ширээ уулын ордын гөлтгөнийг боловсруулж өөрийн орны барилгын болон эмнэлэг, гоёл чимэглэл, хэвний зориулалтын гөлтгөнө үйлдвэрлэн ашиглаж Хөтөл, Дарханы цементийн үйлдвэрийг хангах улмаар гадаадад /Хятад, Солонгос/ экспортлох боломжтой.

Аймгийн нийт сумдын 73,3 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдож цахилгааны найдвартай хангамжтай болсон нь үйлдвэрлэл эрхлэх таатай орчин бүрдүүлээ.Гэсэн хэдий ч эрчим хүчний ашиглалтын түвшин доогуур, орон нутгийн орлогод дорвитой хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл хөгжүүлж чадахгүй байна.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж үйлдвэрлэлийн салбарт оруулснаар аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгах, хүн амыг өргөн хэрэгцээний бараагаар хангах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, хөгжилтэй орны шилдэгтехник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ажлын байр олноор бий болгох асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Зорилт:

Орон нутгийн нөөцөд тулгуурлан хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөлгүй технологи ашиглан эрдэс түүхий эдийг олборлон, зохих түвшинд боловсруулалт хийж экспортлохын зэрэгцээ мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрийг түлхүү хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Тэвшийн говийн хүрэн нүүрсний ордыг түшиглүүлэн 12МВт-аас доошгүй чадалтай ДЦС барьж, олборлолтыг нэмэгдүүлэх
- Таргатын гөлтгөнийн олборлолтыг нэмэгдүүлэн барилгын болон эмнэлгийн гипс боловсруулах, барилгын гипсэн хийц, цемент үйлдвэрлэх үйлдвэр байгуулж үйл' ажиллагааг өргөжүүлэх
- Явган замын хавтанцрын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зэргэлдээ аймгуудад борлуулах
- Бетон болон хайрганы цех байгуулж, шохойн үйлдвэрлэл бий болгох
- Барилгын ханын материалын үйлдвэрлэл бий болгох /тоосго, блок, угсармал хавтан, дулаалгын хөөсөнцөр г.м/
- Орон нутгийн материалд тулгуурласан дулааны алдагдал багатай ханын материалын үйлдвэр байгуулах
- Ураны баяжмал экспортонд гаргаж, өндөр илчлэгтэй чулуун нүүрсээр дотоодын хэрэгцээг хангах

- Шар шороот, Булаг Хөөтийн эрдсийн будгийн ордыг ашиглаж тосон будаг үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах
- Эрээний төмрийн ордыг ашиглаж, төмөрлөгийн үйлдвэрт баяжмал нийлүүлэх
- Төмөр болон нүүрсийг экспортлох үйлдвэр байгуулах
- Уул уурхай, барилгын материалын үйлдвэрүүдээс байгаль орчинд учруулсан хор уршгийг арилгуулах үр нөлөөтэй механизм бүрдүүлэх
- Мах болон мал аж ахуйн зарим түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүнийг гаргах
- Ямаа, тэмээний ноос, ноолуурт олон улсын стандартын дагуу боловсруулалт хийх
- Хүнсний үйлдвэрт техник технологийн шинэчлэлт хийж бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Сумдад сүү цагаан идээ боловсруулах жижиг үйлдвэрүүд байгуулах
- Түлш хэмнэж утаа бага гаргадаг зуухны үйлдвэрлэл бий болгох
- Хог хаягдалд ангилалт хийн зарим хэсгийг боловсруулах үйлдвэр байгуулах
- Шахмал түлшний цех байгуулах
- Хүнсний ногоог боловсруулах, савлах жижиг үйлдвэр байгуулах
- Сангийн далайн давсыг үйлдвэрийн аргаар боловсруулж, иоджуулах
- Тогоо, Хадна ус, Исгэлэнгийн рашааныг стандартын шаардлагад нийцүүлэн савлаж ашиглах
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сан бүрдүүлж зориулалтын дагуу үр өгөөжтэй ашиглах
- Хувийн хэвшлийн байгууллагууд жижиг дунд үйлдвэр байгуулах, хөгжүүлэх, үйлдвэрийн газрын бүтцийг өөрчлөн шинэчлэхэд нь дэмжлэг үзүүлэх

ХУДАЛДАА

Одоогийн байдал:

Аймгийн хэмжээнд үндэсний чөлөөт худалдааг хөгжүүлэх, худалдааны байгууллагын үр нөлөөг дээшлүүлэх, хөдөлмөрчдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагын улмаас аймгийн Засаг даргын 2001 оны 43 дугаар захирамжаар "Бөөний худалдааны сүлжээ" дэд хөтөлбөрийг батлуулан аймгийн төвд 3, сум бүрт нэг, нийт 18 түшиц аж ахуйн нэгжийг сонгон баталж санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлж байна.

Эхний ээлжинд өөрийн аймгийн 2 хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэрийн бараагаар бөөний худалдааны сүлжээний эхлэлийг тавьж, Улаанбаатар хотын хүнсний томоохон үйлдвэр /Алтан тариа, АПУ, Өгөөж, Талх чихэр ХК/-ийн салбаруудыг нээн ажиллууллаа. Одоогийн байдлаар аймгийн төвд Өлзий-Дундговь, Их хайрхан Мандал, Бөхт ХХК, Хулд сумын Дүйсэм хоршоо нь 20-50 нэр төрлийн хүнс өргөн хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүн, барилгын материалыг бөөний үнээр худалдаалж байна.

Аймгийн төвд хүнсний захыг нээн ажиллуулж хүнс, мах, сүү, цагаан идээ, түүхий эдийн чиглэлээр төрөлжүүлэн заал зохион байгуулагч, малын эмчийг тогтмол ажиллуулан малчид хөдөлмөрчид илүүдэл бүтээгдэхүүнээ чөлөөтэй худалдаалах нөхцлийг бүрдүүлэв.

Их хайрхан Мандал ХХК нь мал аж ахуйн гаралтай түүхий эдийг худалдан авч, арьс ширэнд анхан шатны тордолт хийн борлуулж байна.

2002 оны байдлаар аймгийн төвд 70 гаруй аж ахуйн нэгж, сум бүрт 2-4 аж ахуйн нэгж, аймаг сумын төвд 250 гаруй иргэд худалдааны үйл ажиллагаа эрхэлж байна. Худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд нь хүнс өргөн хэрэглээний баталгаат чанартай бараагаар хүн амын эрэлт хэрэгцээг хангах, байгууллагынхаа мэргэжлийн боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх талаар шаардлагын түвшинг хангахгүй байна.

Бөөний худалдааны эхлэл тавигдан нааштай алхмууд хийгдэж байгаа боловч бөөний худалдааны сүлжээний дотоод бүтэц, мэдээллийн сүлжээ, бараа түүхий эдийн төрөлжсөн бирж байгуулах, зориулалтын агуулахууд бий болгох асуудлууд удаашралтай байна.

Зорилт:

Хүн амыгчанар сайтай хүнс өргөн хэрэглээний бараагаар хангах, бараа түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн зохистой тогтолцоог бий болгох, бараа түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийг оновчтой болгох замаар бөөний худалдааны тогтолцоог бүрдүүлэн бодит үнийн түвшинг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Эрдэнэдалай, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайнцагаан сумын төвд бараа түүхий эдийн бирж, худалдааны төв байгуулах
- Бөөний худалдааны мэдээллийн сүлжээ бий болгож, хөдөө дах бөөний худалдааны төвүүдийг сүлжээнд холбох
- Сум дундын бөөний худалдааны сүлжээ байгуулах
- Мандалговь хотод бөөний худалдааны нэгдсэн төв байгуулж, сумдад салбар бий болгох
- Аймаг, сумын төвд бараа түүхий эдийн төрөлжсөн, шаардлага хангасан зах, агуулахуудыг байгуулах
- Бараа, түүхий эдийг тээвэрлэх нөхцөл бүрдүүлэх
- Багуудын төвд бараа түүхий эдийн агент ажиллуулах
- Иргэд, хөдөлмөрчид, аж ахуйн нэгж, байгууллагуудад захиалгаар үйлчлэх үйлчилгээг бий болгон өргөжүүлэх
- Төв суурин газруудад төрөлжсөн дэлгүүрүүдийг байгуулах
- Бараа түүхий эдийн технологийн тээврийн үйлчилгээг бөөний худалдааны сүлжээний хүрээнд бий болгох

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Одоогийн байдал:

Ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүд бүрэн хувьчлагдаж үйл ажиллагаа нь хувийн өмчин дээр тулгуурлан явагдах болсон нөхцөлд тэдгээрийг дэмжих, бие даасан үйл ажиллагааг нь хангах, зах зээлийн тогтолцооны зарчимд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээг нь оновчтой шинэ хэлбэрээр зохион байгуулах

шаардлага тулгарч байгаа нөхцөлд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ахуйн үйлчилгээг сэргээж, түүний хүрээг өргөтгөхөд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бий болгох, ажил үйлчилгээний чанарын түвшинд тавих хяналтыг сайжруулах зорилтыг тавин хэрэгжүүлж байна.

Одоогийн байдлаар аймагт ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж 20, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэн 60 байна. Үүнээс 4-30 ортой зочид буудал 17,2-30 хүн нэг ээлжинд усанд орох хүчин чадалтай халуун ус 8, үсчин, зурагчин 28, оёдол, гутал, хувцас засвар 27, төмөр, модон эдлэлийн үйлдвэрлэл эрхэлдэг 6 иргэн, аж ахуйн нэгж ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл үйлчилгээ явуулах байрны хангамж муу, иргэд хөдөлмөрөө хорших хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх идэвх санаачилга дутмаг, хөрөнгө мөнгөний дутагдалтай байгаагаас гадна зайлшгүй шаардлагатай зарим нэр төрлийн / хими цэвэрлэгээ, угаалга/ үйлчилгээ огт байхгүй байна.

Зорилт:

Ахуйн үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийн чөлөөт цагийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Төв суурин газруудын хүн амын хэрэгцээг ахуйн дараах үйлчилгээгээр бүрэн хангах
 - Угаалга, хими цэвэрлэгээ
 - Гутал, хувцас хийх, засварлах
 - Төмөр, модон эдлэл үйлдвэрлэх, засварлах
 - Гэрэл зураг, үсчин, гоо сайхан, цаг засвар
 - Гэр ахуйн техник хэрэгсэл засвар
 - Барьцаалан зээлдүүлэх болон прокатын үйлчилгээ
- Зочид буудал, халуун усны үйлчилгээ
- Гуанз, цайны газар, ресторан, баар, кофены үйлчилгээ
- Үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах зорилгоор явуулын үйлчилгээг бий болгож өргөжүүлэх
- Орон нутгийн түвшинд хүн амд ахуйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд хөдөлмөрөө хоршиход бүх талын дэмжлэг үзүүлж, үйлдвэрлэл үйлчилгээний байраар хангах, идэвхийг дээшлүүлэх, хамтран ажиллах бололцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийг хоршооны сургалтанд өргөнөөр хамруулах
- Ахуйн үйлчилгээний нэр төрөл, хүрээг нэмэгдүүлэн, цаашдаа аймаг, сумдын бүсийн төвүүдэд ахуйн үйлчилгээний төвүүд бий болгох

ЗАМ, ТЭЭВЭР

Одоогийн байдал:

Аймгийн хэмжээгээр 2003 оны байдлаар 1900-аад авто машин, 2000 гаруй мотоцикл гудамж замын хөдөлгөөнд оролцож байна.

Аймаг нийт 3087 км урт байгалийн хөрсөн замтай бөгөөд үүний 240 км нь Улаанбаатар-Мандалговь-Даланзадгадын чиглэлийн сайжруулсан замд тооцогдож байна.

Аймгийн авто тээврийн төвлөрсөн байгууллагууд бүрэн хувьчлагдаж одоогийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээг Шуудан холбооны алба, төрийн бус гэрээт 14 жолооч Улаанбаатар хотоос тендерт шалгарсан компани хамтран орон нутагт тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж байна. Улаанбаатар-Мандалговийн чиглэлд 7 хоногт 3 удаа авто тээврээр, нэг удаа агаарын тээврээр, сумдад газраар нэг удаа авто тээврээр шуудангийн үйлчилгээг гүйцэтгэж байна.

Харин Мандалговь хотын төвд хөдөлмөрчдөд автобусны шугаманд 2 микро автобус, таксийн үйлчилгээ ажиллаж эхэлсэн нь хөдөлмөрчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын эхлэл гэж үзэж байна.

Ачаа тээвэрлэлтийн асуудлыг одоогийн байдлаар ямар ч зохион байгуулалтгүйгээр хувийн хэвшлийн жолооч нар гүйцэтгэж байна.

Хотын хэмжээнд ШТС түшиглэн байгуулагдсан дугуй засварын цехийг эс тооцвол техник засвар, оношлогооны шугам, станцгүй, автокранатын үйлчилгээ огт хөгжөөгүй байна.

Авто замын чанар муу, нэгэнт байгуулсан замыг арчлах тордох ажил хангалтгүйгээс эвдрэлд хурдан орж улмаар авто машины эдэлгээг богиносгодог зэргээс тээврийн салбарын хөгжил хангалтгүй гэж үзэх үндэслэлтэй юм.

Авто тээврийн харилцааг зохицуулах төрийн бодлогыг тодорхойлсон авто тээврийн хуулийг батлан мөрдүүлснээр эрх зүйн орчин бүрдсэн ч тус аймагт тээврийн бодлого зохицуулалтыг явуулахад ихээхэн хүндрэлтэй байна.

Тээврийн хэрэгслэлийн хяналт шалгалтын түвшин ч өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байна. Иймд авто тээврийг бодлого чиглэлтэйгээр хөгжүүлэх, авто тээвэр эрхлэх сонирхол бүхий аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд тавих шаардлагыг өндөржүүлж Монгол Улсын Авто тээврийн тухай хуулийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зорилт:

Монгол Улсын дэд бүтцийн босоо тэнхлэгийн авто замын сүлжээ, төмөр замын хэвтээ тэнхлэгт холбогдож, агаарын тээврийг нэмэгдүүлэн, тээвэр зохицуулалт, хяналтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Улаанбаатар-Мандалговийн чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох, бусад хэсгийн байгалийн хөрсөн замыг засч сайжруулах Үүнд: Мандалговь-Хулд, Мандалговь-Эрдэнэдалай, Мандалговь-Өлзийт
- Мандалговь-Өлзийтийн чиглэлийн авто замыг уул уурхай, аялал жуулчлалын салбарын гол зам болгох
- Дундговь-Чойр, Дундговь-Эрдэнэдалайн чиглэлд гүүр далан байгуулах, байнгын арчилгаатай болгох
- Мандалговь хотын доторх замыг иж бүрэн хатуу хучилттай болгох, замыг тэмдэгжүүлж дуусгах
- Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд тээврийн үйлчилгээг сайжруулах төслийг сонгон шалгаруулах замаар авто тээврийн хуулийн дагуу шаардлага хангасан харилцагчдад тусгай зөвшөөрөл олгож өрсөлдөөний үндсэн дээр ажиллуулах

- Мандалговь хотод нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол, талбай, буудлуудыг стандартын дагуу барьж байгуулах, тохижуулах
- Ойрын сумдад дуудлагаар үйлчлэх таксийн үйлчилгээ бий болгох
- Орон нутагт тээгдэж буй ачаа тээвэрлэлтийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж хот хооронд, дамжин өнгөрөх, хот орчмын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах үүднээс аймгийн орох гарах гол замуудад тавих диспетчерийн хяналтыг өргөтгөж авто тээврийн шалган байцаах товчоог байгуулан ажиллуулах
- Авто тээвэр, механизмын прокатын үйлчилгээг бий болгох, авто машин, сэлбэгийн худалдааг өргөтгөх
- Авто тээврийн ашиглалт хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт, сурталчилгаа явуулах, жолооч бэлтгэж буй сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх шалгалтыг тогтмол хийж жолоочийн мэргэжлийн түвшинг өндөржүүлэх
- Нисэх онгоцны буудлын чиглүүлэгч тоног төхөөрөмжийг сайжруулах замаар АН-24, АН-26, АН-2, МИ-8, Покерь зэрэг онгоцыг хүлээн авах боломж бүрдүүлэх
- Нисэх онгоцны аюулгүй ажиллагааг хангах үүднээс буудлыг Мандалговь хотоос 11 км зайтай Ширээ хэмээх газарт нүүлгэн шилжүүлэх
- Алслагдсан зарим сумдад орон нутгийн хөнгөн онгоцны нислэг хийх
- Техникийн үйлчилгээ, оношлогооны станцыг байгуулан ажиллуулж гудамж замын хөдөлгөөнд оролцож буй авто машин механизмын байгаль орчин, хүн амд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах
- Монгол Улсад мөрдөж буй авто тээврийн хэрэгслэлийн стандарт, зорчигч ачаа тээвэрлэлтийн стандарт, энэ талаар олгогдож байгаа тусгай зөвшөөрлийн олголт, түүнийг хэрэгжүүлж байгаа байдалд тавих мэргэжлийн хяналтыг чангатгах
- Уран, нефть, нүүрс, төмрийн хүдрийн судлагдсан ордыг ашиглахтай холбогдуулан Шивээговь-Хараатын чиглэлд 60 км төмөр зам тавих
- Хараат-Баянжаргалан-Мандалговь-Эрдэнэдалай-Баянтээг гэсэн чиглэлд 400 орчим км төмөр зам тавьж, төмөр замын сүлжээнд холбогдох
- Авто замын босоо тэнхлэгт холбогдох
- Өөрийн аймгийн зам ангийг томсгон бие даалгаж, боловсон хүчин, техник хэрэгслэлээр бэхжүүлэн, замыг шинээр барих, арчлах ажлыг ихэсгэн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Аймгийн төвийн замын уулзваруудад орчин үеийн гэрлэн дохио тавих
- Авто машины засвар үйлчилгээний газруудыг байгуулах
- Авто тээвэр нийтийн зорчигч үйлчилгээний авто бааз байгуулж ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж бодлогоор зохицуулж ажиллах
- Хүн тээврийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч авто тээврийн хэрэгслэлээр хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй ачаа, зорчигч тээвэрлэх дүрэмд тавих мэргэжлийн байгууллагуудын хяналтыг эрс сайжруулах
- Аялал жуулчлалын хүрээ өргөжиж байгаатай холбогдон тэдэнд үйлчлэх ажлыг соёлч, шуурхай байлгаж үйлчилж буй тээврийн хэрэгслийн стандартыг ямагт хангаж ажиллах

МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ

Хамрах хүрээ:

Мэдээллийн технологийн хөгжил Холбооны хөгжил

Мэдээллийн технологийн хөгжил

Одоогийн байдал:

Өндөр хурдацтайгаар хөгжиж буй мэдээлэл холбооны технологи дэлхий дахины хөгжлийн хандлага, нийгэм эдийн засгийн харилцаа, хүмүүсийн амьдралын хэв маягийг үндсээр нь өөрчилж байна. Сүүлийн жилүүдэд манай улсад мэдээллийн технологийг бий болгох, дэлхийн бусад улс орнуудын амьдралд шалгагдсан мэдээллийн технологийг өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах асуудалд улам бүр анхаарч эхэллээ.

Энэ нь юуны түрүүнд компьютерийн орчин үеийн техник хэрэгслэл бидний амьдралд идэвхтэй орж ирсэн, харилцаа холбооны систем улам бүр сайжирч, гадаад харилцаа өргөжин тэлж байгаатай салшгүй холбоотой.

Дундговь аймаг энэхүү мэдээлэл, холбооны технологийн хөгжлөөс хоцролгүйгээр интернетийн сүлжээнд холбогдон албан байгууллага, ард иргэд нь хүссэн цагтаа дэлхийн аль ч өнцөг булантай холбогдож, мэдээлэл солилцох бүрэн боломжтой болжээ.

Холбооны салбарын өнөөгийн түвшин нь зөвхөн телефон яриаг автоматжуулах төдий бус мэдээллийг электрон хэлбэрт оруулан дамжуулах боломжтой болсноор холбоо, мэдээллийн салбар болж үйлчилгээ нь өргөжих боломжтой юм.

Зорилт:

Бүх салбарын үйл ажиллагааг электрон хэлбэрт шилжүүлж, бүх нийтийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулан, интернет, мэдээллийн технологийн хэрэглээг бий болгосноор мэдээлэл холбооны технологийн салбарыг жинхэнэ ёсоор бүрдүүлж эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн хурдасгуур болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

- Мэдээллийн технологийн сургалтын төв байгуулах
- Мэдээлэл холбооны технологид тулгуурласан бүх төрлийн үйлчилгээг дэмжин хөгжүүлэх
- Төрийн албан хаагчийн ажлын байрны автоматжуулалтын түвшинг нэмэгдүүлэх
- Төрийн байгууллага хоорондын үр өгөөжтэй мэдээллийн харилцааг хөгжүүлэх
- Мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ байгуулж ажиллуулах
- Интернетийн сүлжээг ашиглан дэлхийн улс орнуудтай мэдээллийг чөлөөтэй солилцох
- Яам, агентлагуудтай сүлжээгээр мэдээлэл солилцох
- Мэдээллийн санг интернетийн сүлжээгээр тархаах, Онлайн үйлчилгээ бий болгох

- Хэрэглэгчдэд сүлжээгээр дамжуулан мэдээллийн санд харьцаж мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэх, интернетийн сүлжээгээр мэдээлэл хүлээн авах боломжийг сайжруулах
- Мэдээлэл тархаалт үйлчилгээний боловсон хүчнийг сургаж бэлтгэн, дадлагажуулах
- Орон нутгийн байгууллагын хүрээнд мэдээлэл тархаалтын стандартыг бий болгох, мэдээллийн төрөл хэлбэр, техник хэрэгслэлийг ижил түвшинд хүргэх
- Орон нутгийн байгууллагууд, бүх сумдтай электрон шуудангаар харилцаж мэдээлэл авах
- Электрон үйлчилгээг иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлэх
 - Номын сангийн захиалга, эрэлт, хайлтын үйлчилгээг электрон хэлбэрт оруулах
 - Web-д суурилсан зайны сургалт
 - Чөлөөт цагийн үйлчилгээ /Номын сан, музей, тоглоомын төв/-нд электрон үйлчилгээг нэвтрүүлэх
- Радио телевизийн сүлжээг шинэчилж, тоон технологит шилжүүлэх

Холбооны хөгжил

Одоогийн байдал:

Дундговь аймгийн төв нь Улаанбаатартай суурь сүлжээний YISAT сансрын холбоо, аналог болон тоон радио релейны шугамаар холбогдсон ба аналог болон тоон технологитой. Аймгийн төвд 2500 номерын тоон АТС суурилагдсан. Нийт 1362 хэрэглэгчтэй, хэрэглэгчийн 45 хувь нь хот хоорондын болон улс хоорондын телефон ярианы автомат эрхтэй. 2002 оноос эхлэн 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий станц ашиглалтанд орж хөдөлгөөнт холбооны үйлчилгээ явагдаж эхэлсэн. Мөн аймгийн төвд интернет кафе ажиллаж байна. Одоогоор 18 хэрэглэгч интернетийн эрх авч үйлчлүүлж байна.

Аймаг сумын хооронд агаарын шугамаас гадна радио линк суурилагдаж ЕАХ-ын үйлчилгээ явуулж байгаа боловч төхөөрөмжийн хүчин чадлаас шалтаалан тасралтгүй хэвийн ажиллаж чадахгүй байна. Сумдад 48-252 номерийн багтаамжтай АТС ажиллаж байгаа бөгөөд салбарууд нь нарны болон төвлөрсөн эрчим хүчинд холбогдон цахилгаан хангамж сайжирсан. Гэвч сумдын АТС нь нэгдсэн сүлжээнд холбогдох боломжгүй. Сум, багийн хооронд радио станцуудаар холбоо барьж байгаа боловч мөн телефон ярианы зориулалтгүй нэгдсэн сүлжээнд холбогдох боломжгүй. Багаас малчин өрхтэй харьцах холбоогүй. Эрдэнэдалай, Луус, Хулд, Өндөршил, Дэлгэрхангай сумдаас бусад сумын төвд төвлөрсөн радио сүлжээгүй. Бүх сумдад зөвхөн Монгол телевизийн программ хүлээн авч байна.

Зорилт:

Сумдад КАТВ-г, 100 хүнд ногдох телефон цэгийн тоог 50-д хүргэх ба орон нутгийн цахилгаан холбооны сүлжээг зохион байгуулан, иргэдийн аюулгүй байдал өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах дохиолол хамгаалалтын сүлжээ системтэй болох, мэдээллийн технологийг үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйд өргөн нэвтрүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- КАТС-уудыг солих

- Эрдэнэдалай, Өндөршил, Гурвансайхан сумдыг нэгдсэн системд холбох С/12/48-уудыг сүлжээнд холбох техникийн нөхцлийг бүрдүүлэх Малчин өрх багийн төвтэй систем болон сансрын холбооны төхөөрөмжөөр холбоо барих ажлыг турших
- Өдөр дутмын сонин хэвлэл болон бусад мэдээллийг авах мэдээллийн төвийг сумдын 50 хувьд байгуулах
- Аймгийн төвийг нэгдсэн сүлжээнд өндөр хурдтай, багтаамжтай дамжуулах байгууламжаар холбох
- Аймгийн төвийн КАТВ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж бүсийн төвүүдэд орон нутгийн мэдээллийн сувагтай болох
- Шуудангийн сүлжээг багийг хамруулан зардал багатайгаар өртөөчлөн хүргэх зэрэг арга замаар хүртээмжтэй зохион байгуулах Шуудангийн илгээмжийн үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах
- Хүн амын 50-аас доошгүй хувийг интернетэд холбогдох техникийн боломжоор хангах
- Сумдын төвийн АТС-уудын багтаамж, бусад үйлчилгээг нэмэгдүүлэх холбогдох яам, агентлаг, бизнесийн байгууллагуудтай хамтран бүх багуудад нэгдсэн сүлжээнд холбох хөрөнгө оруулалт хийх
- Фермерүүдийг холбоожуулах бүх суманд мэдээллийн төв байгуулах
- Бүх суманд орон нутгийн телевизийн мэдээллийн сувагтай болох

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ

Цахилгаан хангамж

Одоогийн байдал:

Дундговь аймаг нь Чойроос 110 квт-ын цахилгаан дамжуулах шугамаар холбогдсон, тус аймгийн 11 сум, суурин эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон бөгөөд 4 сум Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар олгосон АД-60, АД-100 маркийн дизель цахилгаан станцаас эрчим хүчээр хангагдаж байна.

Тус аймгийн ихэнх нутгаар жилд 270-300 хоног цэлмэг, нар шаралтын хугацаа жилд 2250-3300 цаг, нарны эрчим хүчний дундаж хэмжээ жилд 1400 квт цаг/ м², нарны цацралт 4,3-4,7 квт цаг/м² 12 өдөр бөгөөд салхины эрчим хүчний ашиглаж болох нөөц нь 3500-4600 цаг байгаа нь малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Зорилт:

Бүх сумдыг төвлөрсөн эрчим хүчний системд холбон эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгож, малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Адаацаг, Баянжаргалан, Өндөршил, Өлзийт сумд, Хөөтийн нүүрсний уурхайг төвлөрсөн эрчим хүчний системд холбох
- Багийн төв болон малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах Эрчим хүчний ашиглалтын түвшинг дээшлүүлэх замаар нэг квт цахилгааны үнийг бууруулах

- Чойр Мандалговийн цахилгаан дамжуулах шугамыг Таван толгойн коксжих нүүрсний уурхайтай 220 квт-ын шугамаар холбох Сум бүрийг аваарын цахилгаан станцтай болгон бэлэн байдлыг хангах
- Сумын төвийн 04-н кв-ын шугамыг мэргэжлийн байууллагад шилжүүлж, ашиглалт үйлчилгээг хариуцуулах

Төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдоогүй сумд	ТЭХС-д холбох хугацаа	Хүчин чадал		Шаардагдах хөрөнгө /сая төг/	Тайлбар
		Хэмжих нэгж	Тоо хэмжээ		
Баянжаргалан	2003-2004 он	кв квт	52 35	670,0	1997 онд АД-60*2 дизель
Өндөршил	2004-2005 он	кв квт	65 115	795,0	1997 онд АД-60*2 дизель
Өлзийт	2004-2005 он	кв квт	85 35	990,0	1997 онд АД-100*2 дизель
Адаацаг	2003-2004 он	кв квт	64 115	786,0	1998 онд АД-60*2 дизель

Сумдыг цахилгаан дамжуулах шугам сүлжээнд холбоход нийт 3,2 тэрбум орчим төгрөг зарцуулагдах бөгөөд төлөвлөж байгаа нийт 266 км урт шугамын 85 км нь 35 квт-ын шугам байна.Өлзийт, Өндөршил сумдад нар, салхины эрчим хүчийг өндөр хүчдэлийн шугамтай хосолсон байдаар ашиглах бололцоотой.

Дулаан хангамж

Одоогийн байдал:

Дундговь аймаг нь говь хээрийн бүсэд оршдог, галлагаатай үеийн үргэлжлэх хугацаа 214-226 хоног, гадна агаарын тооцооны хэм нь байршлаас хамаарч -25° С-аас-30,2° С байна. Дундговь аймгийн төв Мандалговь хот болон бусад сум суурингийн төвүүдийн барилга байгууламжийн дулааныг хатуу түлшээр ажилладаг БЗУИ-60, НР-18, маркийн 27-53 м² халаах гадаргуутай зуухнаас хангаж байна.

Хөдөө орон нутагт малчид нүүрс, мод, аргал зэрэг түлшийг амьдрал ахуйдаа өргөн хэрэглэж байна. Аймаг жилд 50000 тн нүүрс олборлох хүчин чадалтай Тэвшийн говь, Хөөт, Цагаан -Овоогийн уурхайгаас нүүрсээр хангагдаж байна.

Мандалговь хотоос бусад сум, суурин газрын дулааныг НР-18 маркийн 27 м² халаах гадаргуутай зуухаар хангаж байна.Нийт 15 сум суурингаас Цагаандэлгэр, Луус, Тэвшийн уурхай НР-18 маркийн 27 м²*2 халаах гадаргуутай тогоогоор, бусад нь нам даралтын тогоогоор дулаанаа хангаж байна.

Үйлдвэрлэсэн дулааныг яндан хоолойгоор дамжуулан түгээдэг, яндан хоолой нь 2 хоолойт үл нэвтрэх тоосгон болон бетон сувагт угсрагдсан байна. Дулааны суваг нь дулаалгын техникийн шаардлага хангахгүйгээс дулааны алдагдал 20-30 хувьтай байна. Халаалтын систем нь ихэвчлэн 2 яндантай мухардмал системтэй бөгөөд халаах хэрэгслэл нь ширмэн радиаторууд байна.

Мандалговь хот болон бусад сумдын төвд 40-250 мм хүртэл диаметртэй, 10 км орчим шугамтай. Эдгээр хоолой нь дулаалга муу, халаалт, арматурын хувьд усны алдагдал ихтэй. Энэ алдагдал нь жилд дунджаар 5000 гаруй тн нүүрсийг үр ашиггүй зарцуулж байна гэсэн үг.

Зорилт:

Дулаан хангамжийн найдвартай байдлыг хангаж дулааны алдагдлыг бууруулах замаар дулаан хангамжийн өртгийг хямдруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Шинээр төлөвлөх барилга байгууламжийн хашилга, хийцэд дулааны алдагдал багатай материал ашиглах замаар дулааны алдагдлыг багасгах
- Ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын хашилга, хийцийн дулаан дамжуулалтын байдалд судалгаа хийж дүгнэлт гарган дулаалах
- Дулааны эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах үүднээс PJ маркийн зуухыг орон нутгийн нөхцөлд тохируулан шинэчилж Тэвшийн уурхайн нүүрсээр ажиллах боломжийг судалж нэвтрүүлэх
- Шинээр төлөвлөх зуухны ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх арга хэмжээ авах
- Судлагдсан нефтийн талбайд нарийвчилсан судалгаа хийж дагалдах бүтээгдэхүүнийг ашиглах асуудлыг шийдвэрлэх
- Байгууллага, аж ахуйн нэгж бүрийн жижиг уурын зуухыг цөөрүүлж, дулааны нэгдсэн сүлжээнд холбох

УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА

Одоогийн байдал:

Аймгийн төвийн орчимд хуримтлагдсан газар доорхи усны нөөц хомсдсоны улмаас Уул уурхай, геологийн яамны /хуучин нэрээр/ гидрогеологийн анги 1980 оноос усны эрэл хайгуул судалгааны ажлыг явуулж аймгийн төвөөс 35 км-т орших Олгойн говийн талбайд ундны зориулалтаар ашиглаж болох усны нөөцийг илрүүлэн тогтоосон. Энэ нь ундны усны стандартын шаардлагыг хангасан бөгөөд хоногт 2676 м³-ээр тооцоход 15-20 жилийн нөөцтэй гэж тогтоогдсон.

Одоогийн байдлаар Олгойн говиос завсрын 3 насосны станцын тусламжтайгаар 200 мм-ийн голчтой хос ган хоолойгоор дамжуулан У-1000 м³-ийн багтаамжтай цутгамал төмөр бетон усан санд шахдаг. Энэ цутгамал усан сангаас хотын унд ахуйн хэрэгцээний ус нь өөрийн урсгалаар хотын 100 мм-150 мм-ийн голчтой цагираг шугамаар дамжин төвийн хэрэглэгчдийг хангадаг. 1986-1988 онд Олгойн говьд 5 цооног гаргаж төхөөрөмжлөн ус дамжуулах төвлөрсөн системийг барьж ашиглалтанд оруулсан бөгөөд одоогийн байдлаар ус дамжуулах байгууламжийн систем ашиглалтын шаардлага хангахгүй болж усны алдагдал их хэмжээгээр гарах болоод байна.

Хотын аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны барилгуудад төвлөрсөн системээс, гэр хороололд ус түгээх 13 цэгээс болон автоцистернээр ус зөөвөрлөн хангадаг ба хотын усны хоногийн хэрэглээ 400-700 м.куб/хоног байна.

Олгойн говийн ордын ус нь одоо мөрдөж байгаа стандартаар хүний ундны усанд тохирно гэж тогтоогдсон боловч зэв ихтэй, кальци магнийн харьцаа алдагдсанаас хүний биед зохимж муутай, иймээс 2000 онд төвлөрсөн системийн орон сууцанд ус өгдөг хэсэгт хоногт 128 м.куб ус цэвэрлэх хүчин чадалтай Франц улсын ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулсан.

Аймгийн төвийн хэрэглэгчид зардал өндөртэй ус хэрэглэж байгаа бөгөөд усны нөөц багасч байгаа зэргийг үндэслэн тус аймагт одоо ашиглаж байгаа усны нөөцөө нэмэгдүүлэх зорилгоор Чех улсын 1,5 сая ам.долларын өртөг бүхий буцалтгүй тусламжаар усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх 4 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлэх ажлын эхний үе шатны үйл ажиллагаа явагдаж байна. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийг 2004 оноос хэрэгжүүлж эхлэх юм.

Мандалговь хотын анхны цэвэрлэх байгууламж 1977 онд ашиглалтанд орсон уг байгууламж шаардлага хангахгүйн улмаас 1998 онд шинээр 367 сая төгрөгийн өртөгтэй, хоногтоо 2100 м³ бохир ус цэвэрлэж чадах хүчин чадалтай байгууламжийг ашиглалтанд оруулж түүнээ ашиглаж байна.

Мандалговь хотоос бусад бүх сумын төв төвлөрсөн ус хангамжийн системгүй бөгөөд 1989 оны үед сумын төвүүдэд 1-4 өрөмдмөл худаг ашиглагдаж байсан бол 1997 онд Баянжаргалан, Луус, Адаацаг, Говь-Угтаал сумын төвд 1 -2 өрөмдмөл худаг хүн амын ундны усны болон төмс, хүнсний ногооны талбай услах, халаалтын зууханд ус өгөх зориулалтаар ашиглагдаж сумын төвийн ус хангамж үндсэндээ гар татлагатай энгийн худгаас хангагдах хэмжээнд хүрсэн юм.

Харин 1998-1999 онд гадаадын төслийн хөрөнгөөр 10 сумын төвд хүн амын ундны усны зориулалттай гар насостой 19 худаг ашиглалтанд оруулсны 6 нь эвдэрч ашиглагдахгүй байна.

Геологийн болон усны байгууллагаас сумдын төвийн усны нөөцийг ямар нэг хэмжээнд тогтоосон боловч Өлзийт, Хулд, Адаацаг сумын усны нөөц тогтоосон цэг нь төвөөсөө 3-12 км-т байрладаг, 1989 онд сумдын төвийн ус хангамжид ашиглагдаж байсан 68 өрөмдмөл худгийн ихэнх нь буюу 5-аас бусад нь тоног төхөөрөмж нь тоногдож, цооногийг нь түгжсэнээс 10-аас бусад нь дахин сэргээн засварлах боломжгүй болсон байна.

Нэг сумын төвд 110-330 өрх, 400-1400 хүн амьдардаг бөгөөд хоногийн усны хэрэглээ 7,5 м.куб/хоногоос хэтрэхгүй байгаа бөгөөд сумын төвүүдийн одоо ашиглаж байгаа энгийн гар худгуудын ус нь хими, бактериологийн шинжилгээгээр хүний унданд тохирохгүй гарч байна. Өөрөөр хэлбэл тус аймгийн аль ч сумын төвийн хүн ам чанартай, хүрэлцээтэй усаар хангагдаж чадахгүй байна. Цаашид ус ихээр хэрэглэдэг үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, төвлөрсөн уурын халаалт тавихад усны хүрэлцээ хангамж бага байна.

Зорилт:

Төв, суурин газрын хүн амыг чанарын шаардлага хангасан унд, ахуйн зориулалттай усаар найдвартай хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Чех улсын буцалтгүй тусламжаар аймгийн төвийн ойролцоо усны хайгуул хийж шинэ эх үүсвэр, нөөцийг тогтоон, Мандалговь хотын ундны болон үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэх
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төслөөр нийтийн аж ахуйн байгууллагын шугам сүлжээ, Олгойн говийн инженерийн байгууламжийн тодорхой хэсгийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглон сэргээж, ус дамжуулах инженерийн байгууламжид техник, технологийн шинэчлэл хийх
- Гэр хороололд ус түгээх цэгүүдийг сэргээн засварлаж, шинээр барих, ус түгээх цэгийн 80 хувийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох, ус түгээх цэгийг хувийн хэвшилд шилжүүлэх
- Орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж усны өртөг зардлыг бууруулах
- Төв суурин газрын хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийг хамгаалах төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Төвлөрсөн ус хангамжийн системийн тодорхой хэсэгт ус цэнгэгжүүлэх төхөөрөмж тавих
- Ус хэрэглэгчдийг бүрэн тоолууржуулах
- Сумдын төвийн усан хангамж, ариутгах татуургын нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах
- Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумын төвийн өрөмдмөл худгийг сэргээн засварлаж ашиглалтанд оруулах
- Адаацаг, Хулд, Өлзийт сумдын төвд шинээр өрөмдмөл худаг гаргах
- Луус, Эрдэнэдалай зэрэг сумдын ундарга сайтай гүний худгуудад цахилгаан насос суурилуулах
- Сумдын төвийн ус хангамжийн өрөмдмөл худгуудад ус цэнгэгжүүлэх төхөөрөмж тавих
- Ус-21 төслөөр гаргасан эвдрэлтэй байгаа гар насостой худгуудыг ашиглалтанд оруулах

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Одоогийн байдал:

Унаган төрхөө алдаагүй байгальтай, түүх, соёлын арвин баялаг өв сантай, нүүдлийн соёл иргэншил, өвөрмөц зан заншилтай манай орны хувьд аялал жуулчлал бол улс, бүс нутаг, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн нэг хүчин зүйл юм. Манай аймагт аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэхэд тохиромжтой 51,0 мянган га нутаг дэвсгэр байна гэж үздэг.

Манай аймаг Их, Бага газрын чулуу, Цагаан суварга, Морин толгойн цав, Хэвтээ босоогийн агуй, Аргийн хад, Дэл хөнжил, Дэлгэрхангай уул зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд, Олдох, Ээрэмт, Эрэгнэг, Загийн усны говь зэрэг өргөн уудам говиуд, Онгийн хийдийн туурь, Эрдэнэдалайн Цогчин дуган, Үнстийн хийд, Дэлгэрийн зүүн Чойрын жүдийн сан, Суварган сүм, Сүм хөх бүрдийн балгас, хуучин чулуун зэвсгийн үеийн Ярх уул, Их тахилгат, Хар хашаат, Баруун билүүтийн хадны сүг зураг зэрэг түүх дурсгалын үнэт зүйлсээр баялаг юм.

Тус аймагт аялал жуулчлал бол шинэ хөгжиж буй салбар бөгөөд энэ талаар бэлтгэгдсэн өндөр мэргэжлийн боловсон хүчингүй, улсын хэмжээний нэгдсэн сүлжээнд ороогүй байна. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа 6 жуулчны бааз

улирлын чанартай цөөн тооны жуулчин авдаг ба Улаанбаатар дахь жуулчны томоохон аж ахуйн нэгжүүдийн охин компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас орон нутгийн орлогод төдийлөн хувь нэмрээ оруулахгүй байна.

2001 онд "Аймгаас аялал жуулчлалын талаар баримтлах бодлого" нэртэй баримт бичиг боловсруулан гаргасан бөгөөд түүнд юуны өмнө аялал жуулчлал хөгжих угтал нөхцөл болсон дэд бүтцийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, орон нутгийн зочид буудал, үйлчилгээний чанар, нэр төрлийг сайжруулах, аялал жуулчлалын улсын хэмжээний сүлжээнд хамрагдах, спорт агнуур, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Тухайлбал сумдыг халуун ус, зочид буудалтай болгох, сургалт зохион байгуулах, зочид буудлууд, жуулчны баазуудыг аттестатчилах, жуулчны бааз шинээр байгуулах удирдамж гарган төсөл шалгаруулах, аймгийн аялал жуулчлалын маршрут гаргах, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийнхнийг оролцуулан уулзалт ярилцлага зохион байгуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Энэ онд 6 аж ахуйн нэгж шинээр жуулчны бааз байгуулсан, цаашид ч хэд хэдэн бааз байгуулагдах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх эхлэл тавигдаад байна.

Жил бүр гадаадын анчдаар цөөн тооны ховор ан амьтан агнуулах, бариулах арга хэмжээ авч байгаа ба энэ нь байгаль цаг агаарын таагүй байдал, уг амьтны тоо толгой, өсөлт бойжилттой холбоотойгоор явц муутай, цаашид өргөжүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Манай аймгийн цахилгаан эрчим хүч, холбооны үйлчилгээний хангамж, Улаанбаатар хотод харьцангуй ойр, байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар олонтой, дуу хуурын өвөрмөц онцлог зэрэг нь аялал жуулчлал хөгжүүлэх гол нөхцөл болж байна. Харин мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдээгүй, орон нутгийн зам харилцаа сул хөгжсөн, зочид буудал, халуун усны үйлчилгээ төдийлөн шаардлагын түвшинд хүрээгүй, бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавх сайнгүй зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд муугаар нөлөөлж байна.

Зорилт:

Аялал жуулчлалыг дэд бүтцийн биеэ даасан салбар болгон хөгжүүлж, орон нутгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аялал жуулчлал, олон улсын харилцаа, гадаад хэлний өндөр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх
 - Жуулчны бааз, зочид буудал, зоогийн газрууд болон үйлчилгээний бусад салбарт ажиллагсдыг сургах, мэргэшлийг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байх
- Аймаг орон нутгаа гадаад, дотоодод сурталчлах сурталчилгааны олон хэлбэрийг ашиглаж бусдад таниулах ажлыг зохион байгуулах
- Жуулчны гэр баазуудыг бэхжүүлэх, шинээр байгуулах баазуудын байршлыг оновчтой зөв сонгож, бүс нутгийн байгаль цаг уурын онцлогт нийцсэн

архитектур, эрүүл ахуйн шаардлага хангасан бааз байгуулах аж ахуйн нэгж, байгууллагыг бүх талаар дэмжих

- Жуулчны баазуудын байршилд хүрэх зам дагуу тэмдэгжүүлэлт хийх, замыг сайжруулах, хөрс, ус бохирдохоос хамгаалж шаардлага хангасан бохирын цооног, хогийн цэгтэй болгох
- Спорт ан агнуурыг хөгжүүлэхийн зэрэгцээ цаашдаа ховор ан амьтныг агнах, барихыг зохих хэмжээгээр хязгаарлаж, байгалийн аялал, танилцах аялал, нутгийн зан заншилд түшиглэсэн аялал жуулчлалыг /айраг исгэх, эсгий хийх, морь уралдуулах, булгиулах, тэмээ ачих, гэрийн болон бусад найр наадам, цагаан идээ боловсруулах г.м/ түлхүү хөгжүүлэх
- Орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, зочид буудал бусад үйлчилгээний байгууллагын үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Жуулчны баазуудыг орчин үеийн холбоо, мэдээллийн сүлжээнд /сансрын холбоо, интернет/холбох

ГАДААД ХАРИЛЦАА

Одоогийн байдал:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт гадаадын зарим улс орны муж, аймаг, хот, дүүрэгтэй холбоо тогтоон мэргэжилтэн солилцох, сургах, туршлага судлах, ажиллах хүч гаргах, хөрөнгө оруулалт, техник технологийн дэмжлэгтуслалцаа авах. үйлдвэр, аж ахуйн нэгж салбарыг орон нутагтаа нээх замаар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тусгагдсан. Энэ зорилтын хүрээнд жил бүр төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид цөөн тооны хүмүүс Япон, БНСУ, Швед, Франц, ХБНГУ, ОХУ, БНХАУ зэрэг улс орнуудад явж мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн туршлага судалж ажил төрлийн холбоотой ажиллаж байна.

2000-2003 онд аймгаасаа 90 гаруй хүнийг зуучлан Чех, БНСУ-д явуулан ажиллуулж, ОХУ-ын Буряд улсын Хиагт, Бичурин районуудтай түншийн харилцаа тогтоон хамтран ажиллах чиглэлээ тогтоогоод байна.

Гадаадын төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай харилцаа тогтоож хөдөө аж ахуй, нийтийн аж ахуй, нийгмийн хүрээний чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр сүүлийн 2 жилд 15 төслөөр 11.2 тэрбум төгрөгийн зээл тусламжийг авч тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэж байна.

Манай аймаг нь газар зүйн байршлын хувьд гадаадын улс орнуудтай хил залгаа оршдоггүйгээс хил худалдаа, нийгмийн бусад салбарт хамтран ажиллах боломж хилийн аймгуудыг бодвол хязгаарлагдмал байдаг.

Зорилт:

Гадаад түншлэлийн харилцааг өргөжүүлэн, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж орон нутгийн хөгжлийг түргэтгэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Гадаад харилцаа хамтын ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж сурталчлах
- Аймгийнхаа эдийн засаг, нийгмийн давуу тал, ирээдүйн зорилтын талаар мэдээллийг интернет болон бусад сувгуудаар түгээх
- Аймгийн Web-ийг интернетэд байрлуулах

- Ашигт малтмалын хайгуул, олборлолтыг гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ашиглах боломжийг бүрдүүлэх
- Гадаадын хөрөнгө бруулалтаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах экспортын баримжаатай үйлдвэр байгуулах боломж нөхцлийг шийдвэрлэх
- Үйлдвэрлэл эрхлэгчдэд гадаад зах зээлд нэвтрэх арга замын талаарх мэдлэг, чадвар олгох
- Шууд харилцаатай муж, хотуудад болон бусад улс оронд боловсон хүчин сургаж бэлтгэх, дадлагажуулах
- Гадаадын төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, шинээр төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудыг судалж холбоо тогтоох
- Шууд харилцаат муж, хотуудын үйлдвэрлэл үйлчилгээний салбартай хамтран ажиллах гэрээ хэлцэл хийж хөрөнгө оруулах, техник технологийн дэмжлэг авах замаар үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг орон нутагтаа нээн ажиллуулах, өөрийн бүтээгдэхүүнийг борлуулах цэг салбарыг тухайн хот, мужид ажиллуулах
- Хөрш зэргэлдээ зарим улс орнуудад төлөөлөгчийн газар ажиллуулах
- Шууд харилцаат муж, аймаг, хот, дүүргүүдтэй соёл, урлагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ

Одоогийн байдал:

Уур амьсгал

Аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай сэрүүн уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж/Дэлгэрхангай Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумдын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан. цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/гэж 3 хуваадаг.

Агаарын жилийн дундаж температур өмнөд хэсэгтээ 2-4 градус, хойд хэсэгтээ 0-2 градус байдаг бөгөөд сүүлийн 3 жилийн дунджаар 2,5-3,7 градус болсон нь олон жилийн дунджаас харьцангуй өндөр болсон байна.

Тус аймгийн нутаг дулааны хангамж сайтай харин чийгийн хангамж бага, жилд орох хур тунадасны хэмжээ одоогоос 20 жилийн өмнө нутгийн хойд хэсэд 200-250 мм, төв хэсэгтээ 150-200 мм, өмнөд хэсэгтээ 100-150 мм байсан бол сүүлийн жилүүдэд энэ хэмжээ багасч дунджаар 80-110 мм, тухайлбал сүүлийн 3 жилд хур тунадасны хэмжээ 2000 онд хамгийн бага нь Говь-Угтаал суманд 47,1 мм, хамгийн их нь Эрдэнэдалай суманд 167,9 мм, 2001 онд хамгийн бага нь Хулд суманд 41,8 мм, хамгийн их нь Говь-Угтаал суманд 180,9 мм, 2002 онд хамгийн бага нь Дэлгэрхангай суманд 37,9 мм, хамгийн их нь Говь-Угтаал суманд 120,2 мм болсон байна.

Сүүлийн жилүүдэд зуны улиралд хур тунадасны хэмжээ багасахын зэрэгцээ хурц нартай өдрийн давтамж, тоо ихэссэнээр зун, намартаа ган болж байна.

Нутаг дэвсгэрийн өндөржилтийн ялгаа бага учир салхи ихтэй нутагт тооцогддог, олон жилийн дундаж салхины хурд 3-5 м/с, сүүлийн жилүүдийн салхины дундаж хурд хурд 4-6 м/с болж, 12-м/с-ээс дээш цасан болон шороон шуургатай өдрийн тоо ихэссэн, хамгийн их хурд 40 м/с хүрдэг.

Байгаль орчны төлөв байдлын сүүлийн 5 жилийн тайлан мэдээнээс харахад манай орны нутаг дэвсгэр дээр жилдээ 25-30 удаа цаг агаарын аюултай үзэгдэл тохиолдож үүний гуравны нэг орчим нь гамшгийн хэмжээнд хүрч улс, нийгэмд учрах хохирлын хэмжээ жил бүр өсч байна.

Тус аймагт 2001 онд 24-30 м/с-ийн хүчтэй цасан болон шороон шуурга 2 удаа, хүчтэй мөндөр, уруйн үер 2 удаа, 2002 онд дээрх үзэгдэл мөн тус бүр 2 удаа болж хүний амь эрсдэх, мал олноор хорогдох, байшин барилга, гэр хашаа, цахилгааны болон холбооны шугам унах зэргээр улс болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд олон сая төгрөгийн хохирол учирсан байна.

Цаашид 2025 он хүртэлх хугацаанд орох хур тунадасны хэмжээнээс ууршилт нь 6-10 дахин ихсэх, өөрөөр хэлбэл уурамьсгалын өөрчлөлтийн цаашдын хандлага улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл улам хүндэрнэ гэсэн тооцоог мэргэжлийн байгууллагаас гаргаад байна.

Байгаль цаг агаарын дээрх өөрчлөлтөөс эдийн засаг, үүнээс мал аж ахуйн тогтолцоог өөрчлөх, олон мянган жилээр тогтсон амьдралын хэв шинжийг ноцтой хөндөх байдал үүсч байна.

Усны нөөц

Дундговь аймаг жилд орох хур тунадасны хэмжээ бага, газрын доорх усны нөөц хязгаарлагдмал, байгалийн тэнцвэр харьцангуй багатай, усны хатуулаг, эрдэсжилт өндөртэй юм.

Тус аймгийн хүн ам, үйлдвэр үйлчилгээ, бэлчээрийн мал аж ахуйн усан хангамж жилийн 4 улиралд газрын доорхи усаар хангагддаг, гадаргын усны хувьд байнгын тогтмол нуургүй, ихэвчлэн хур борооны усаар тэжээгддэг цөөн тооны булаг, шандтай, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдын нутгаар 44,0 км үргэлжлэх Онгийн голын ус сүүлийн жилүүдэд голын эх дээр олон алтны үйлдвэр үйл ажиллагаа явуулснаас болж тасардаг болсон.

Гадаргын усны нийт нөөц 0,005 км куб/жил, үүнээс ашиглаж болох нөөц тогтоогдоогүй, газрын доорх усны нөөц 0,12 км куб/жил үүнээс ашиглаж болох нөөц 0,06 км куб/жил гэж тогтоогдсон.

Аймгийн нутаг дэвсгэрт 1960 оноос геологийн болон усны аж ахуйн байгууллагаас газрын доорхи усны эрэл хайгуул судалгааны ажил явуулж, аймаг, сумдын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоох, бэлчээрийн мал аж ахуйн усан хангамжийн зориулалттай олон зуун усны барилга байгууламж барьж, газрын доорхи усны талаар ихээхэн материал хуримтлагдсан юм.

Харин газрын доорхи усны ашиглалт, нөөцийн байдалд байнгын ажиглалт судалгаа, үнэлгээ хийж, энэ талаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах ажил учир дутагдалтай байна. Мөн усны нөөцийг хомсдох, бохирдохоос сэргийлэх ажил шаардлагын хэмжээнд хийгдэхгүй байна.

Ургамал, ан амьтан

Аймгийн нутагт 500 шахам төрлийн ургамал ургадаг бөгөөд их таван салаа / Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Цагаандэлгэр, Гурвансайхан/, дагуур арц/Дэлгэрхангай/, чихэрөвс /Дэрэн, Сайнцагаан, Өндөршил/, сөд/Дэлгэрхангай, Дэлгэрцогт/, морин зээргэнэ /Дэлгэрхангай/, тарваган шийр /Эрдэнэдалай, Дэлгэрцогт/, гоёо /Дэлгэрхангай, Хулд, Өлзийт/, цулхир /Өлзийт, Өндөршил, Гурвансайхан/, морин шарилж/ Гурвансайхан, Өндөршил, Баянжаргалан/, халгай /ихэнх суманд/, нохойн хушуу /Дэлгэрхангай, Гурвансайхан,

Дэлгэрцогт/, гоньд/Адаацаг/, шаргал лидэр /Гурвансайхан, Дэлгэрцогт/, хэрээ нүд/Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан/, алтан гагнуур /Гурвансайхан/ зэрэг ховор болон эмийн 20 гаруй төрлийн ургамал байдаг бөгөөд эдгээрийг эмийн зориулалтаар бага зэрэг ашиглаж байна.

Тус аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар нийт нутаг дэвсгэрийн 0,78 хувь буюу 58,6 мянган га нь ойн сан бүхий газар үүнээс 27,1 мянган га нь ойгоор /заган ой/ бүрхэгдсэн талбай байна. Заган ой бүхий Өлзийт сумын Загийн усны хоолойг улсын тусгай хамгаалалтад авч /нөөц газар/ байгаль хамгаалагч томилон ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын 2001 оны 02 албан даалгавраар заг болон модлог, бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг хориглосон. Мөн жил бүр улсын төсвийн хөрөнгөөр 50-80 га-д заган ойн нөхөн сэргээлт хийж байгаа боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Цаашид заган ойг хамгаалах, булаг, шандын эх, төв суурин газрыг ойжуулах арга хэмжээг өргөн олон түмний идэвхтэй оролцоо, гадаад орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр гүйцэтгэх бодлого баримталж ажиллах шаардлагатай байна.

Мэргэжлийн байгууллагаас 1998 онд хийсэн ангийн тооллогоор аргаль /1000 гаруй, Өндөршил, Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Адаацаг, Гурвансайхан, Баянжаргалан/, янгир /400 гаруй Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Адаацаг/, хар сүүлт /4000 гаруй Өлзийт, Гурвансайхан, Өндөршил, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо/, цөөн тооны шилүүс /Өлзийт, Гурвансайхан/ зэрэг ховор ан амьтан, тарвага /25,8 мянга Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайнцагаан/, цагаан зээр /24,6 мянга урд талын сумдад байнгын бусад сумдад нүүдлийн байдлаар/ зэрэг ан амьдтын тоог тогтоосон бөгөөд сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, зуд, хууль бусаар агнах байдлаас дээрх тоо толгой эрс цөөрөөд байна. Тухайлбал 2001 онд ан агнуурын "МОНРИЕЛ" ХХК, ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс хийсэн аргаль хонины тооллогын дүнгээс харахад 1998 оныхоос аргалийн тоо толгой 41,8 хувиар буурсан байна. Мэргэжлийн байгууллагаас нарийн тогтоогоогүй боловч үнэг, хярс, мануул, туулай эрс ховордож, тарваганы тоо, толгой ч эрс цөөрсөн

Жилд гадаадын анчдаар цөөн тооны /5-10/ аргаль, янгир, хар сүүлт, чоно, цагаан зээр агнуулах, шонхор шувуу барих /8-10/, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээр ахуйн зориулалтаар /500-1000/ тарвага, цагаан зээр агнуулдаг, харин үлийн цагаан оготно ихэссэнтэй уялдуулж үнэг, хярс атнахыг аймгийн ИТХ-ын тогтоолоор хориглоод байна.

Агаарын чанар, орчны бохирдол

Улаанбаатар, бусад томоохон хот сууринтай харьцуулахад тус аймгийн төв сум, суурин газрын агаарын бохирдол харьцангуй бага боловч сүүлийн жилүүдэд төвлөрсөн халаалтын систем алдагдаж байгууллага, аж ахуйн нэгж бүр өөрийн бага оврын халаалтын зуухтай болсон, стандартын шаардлага төдийлөн хангахгүй шатахуун түгээх станц олноор бий болсон, автомашины тоо ихэссэн нь цаашид агаарын болоод орчны бохирдлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Хот суурин газрын хог хаягдлыг зайлуулах систем боловсронгуй биш, хогийн нэгдсэн цэг талбай байгаа боловч төвлөрсөн цэгт хогоо асгаж хэвшээгүй, төв суурин газрын орчим болон худаг өвөлжөө, хаваржааны газрыг цэвэрлэх, ариутгах ажил муу хийгдэж байгаагаас хөрс болон хөрсний ус ахуйн хог хаягдал, үхсэн малын сэг зэмээр бохирдох, хүн амын ундны усны ариун цэврийн нөхцөл сайжрахгүй байгаагаас ус бохирдох байдал байсаар байна. Хогийг ялгах, дахин боловсруулах асуудал огт хийгдэхгүй байна.

Аймгийн төвд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжөөр 2002 оноос "Эрүүл хот" төсөл, Дэлхийн банкны санхүүжилтээр "НАА-г хөгжүүлэх төсөл" хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд цэвэр, бохир усны системийг сайжруулах, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар тодорхой ажил, асуудал төлөвлөгдөн хэрэгжиж эхэлж байна. Мөн аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны алба, ХХААГ-аас жил бүр төв суурин газрын хог хаягдлыг цэвэрлэх, орчноо тохижуулах, мал эмнэлэг, ариун цэврийн аян зохион байгуулах арга хэмжээ авч байна.

Газрын /бэлчээрийн/ байдал. Цөлжилт

Аймгийн 7469,0 мянган га газар нутаг дэвсгэрээс хөдөө аж ахуйн газар 7356,0 мян.га буюу 98.5%, хот тосгон бусад суурины газар 10,3 мян.га буюу 0.14%, зам шугам сүлжээний газар 29,3 мян.га буюу 0.39%, ойн сан бүхий газар 58,6 мян.га буюу 0.78%, усны сан бүхий газар 8,8 мян.га буюу 0.12%, тусгай хэрэгцээний газар 5,5 мян.гатустус эзэлж байна. Мэргэжлийн байгууллагаас хадлан, газар тариаланд тохиромжтой, энэ зориулалтаар ашиглаж байгаа газар байхгүй гэж тогтоосон бөгөөд ургамлын үндэс сийрэг, тачир, сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутаг дэвсгэрт ган болж, үүний давтамж, хурц нартай өдрийн тоо жил бүр нэмэгдэж, мөн хүчтэй шороон шуурга, салхитай хоногийн тоо нэмэгдэж, бэлчээрийн ургамлын хэмжээ, төрөл сүүлийн 10 жилд 30 хувиар буурчээ.

Аймаг, сумын төв, суурин газрын орчмын хөрс хүчтэй элэгдэл эвдрэлд орж цөлжилт эрчимжиж байгаа бөгөөд нийт нутгийн 17,6 хувь нь хүчтэй, 41,7 хувь нь дунд зэрэг, 40,5 хувь нь сулавтар байдлаар илэрсэн гэж тогтоогдоод байна.

Тус аймагт байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц сонин тогтоцтой, ховор амьтан, ургамалтай, түүх соёлын дурсгалт газруудолон байдгаас говийн модлог ургамал болох заган ой бүхий Загийн усны хоолойг улсын тусгай хамгалалтад /байгалийн нөөц газар/, байгалийн үзэсгэлэнт, ховор ан амьтан ургамалтай Их газрын чулуу, Бага газрын чулуу, Дэлгэрхангай уул, өвөрмөц сонин тогтоцтой Өөш манхан, Цагаан суварга, түүх соёлын дурсгалт Сүмхөхбүрд, Хүрэндух, Онгийн хийд зэрэг 10 гаруй газрыг аймгийн тусгай хамгаалалтад авч, эдгээрээс 2-3 газрыг улсын тусгай хамгаалалтад оруулахаар бэлтгэж байна.

Өнгөрсөн оны 6 дугаар сард Газрын тухай хуулийг шинэчилж, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдаж, улс, аймаг, сумын хэмжээнд дээрх хуулийг хэрэгжүүлэх бүтэц бий болсон нь газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, харилцааг боловсронгуй болгох, газрын шинэтгэлийг эрчимжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

Харин газрын харилцааны талаархи хууль эрх зүйн мэдлэг бүх түвшинд хангалтгүй, газрын албаны мэргэжилтнүүд болон сумдын Тамгын газрын газрын даамлуудын мэдлэг дадлага дутмаг, материаллаг бааз дутагдалтайгаас хууль тогтоомжийн хэрэгжилт сайнгүй байна.

Бэлчээрийн үлийн цагаан оготнотой тэмцэх, төв сууринд мод зүлэг тарих, бэлчээрийг хаших, отрын нөөц нутаг тогтоох, хуваарьтай ашиглах, бууцны хөл, хашсан бэлчээрт тэжээлийн ургамал тарих, говийн заг, мод, бутлаг ургамлыг түлшинд хэрэглэхийг хориглох зэрэг арга хэмжээ авч байна.

Зорилт:

Байгалийн нөөцийг зохистой ашиглаж, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг сайжруулан, нөхөн сэргээх арга хэмжээг нэмэгдүүлэх замаар байгалийн нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэн байгалийн доройтлыг багасган, унаган төрхийг нь

хадгалах, энэ арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, олон түмний хамтын ажиллагааг сайжруулах бодлого баримталж ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Цаг уурын талаар

- Байгаль цаг агаарын өөрчлөлтөд зохицон, байгалийн аюул, ган, зудыг хохирол багатай давахын тулд одоогийн байдалдаа шинжлэх ухааны үндэстэй зөв дүгнэлт хийж, байгалийн унаган төрх алдагдах аливаа үйл ажиллагааг багасган, байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сайжруулах, орон нутгийн ус цаг уур орчны шинжилгээний төв, цаг уурын станц, харуулуудын боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, багаж тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулах арга хэмжээ авах

Усны нөөцийн ашиглалт хамгаалалтын талаар

- Онгийн голын усны нөөцийг хамгаалах, булаг, шандын усны нөөцийг багасах, бохирдохоос хамгаалах арга хэмжээ авах
- Бэлчээрийн болон төв суурингийн ус хангамжийн худгуудын ашиглалт, эзэмшилтийг сайжруулах
- Төв суурингийн хүн амын ундны усны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах

Ургамал, ан амьтны талаар

- Ховордсон болон эмчилгээний чанартай ургамлын тархалт, одоогийн байдалд шинжлэх ухааны үндэстэй судалгаа үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ашиглах, хамгаалах арга хэмжээг боловсруулж шийдвэрлэх
- Тарвага агналтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, ховор ан амьтныг агнах ажлыг хязгаарлах бодлого баримтлах, ан амьтан, ургамал байгалийн бусад баялгийн нөөц, тоо хэмжээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр зохистой ашиглах

Агаарын чанар, орчны бохирдлын талаар

- Төв суурин газрын агаарын чанарын байдал, байгаль орчны бохирдлын шинжилгээ судалгааны ажлын үр нөлөөг дээшлүүлэх
- Төв суурин газрын байгууллага, аж ахуйн нэгжийн халаалтыг төвлөрсөн халаалтын системд холбох, шатахуун түгээх станцыг шинээр байгуулахыг аль болохоор хязгаарлах, одоо ажиллаж байгаа шатахуун түгээх станцын аюулгүй ажиллагааг сайжруулах
- Төв суурин газрын хог хаягдлыг зохистой шийдэх, хогийн цэгүүдийг цэгцлэх, хог хаягдлыг ялгах, зөөх, дарж устгах менежментийг боловсронгуй болгох, хөрсийг эрүүлжүүлэх

Газрын нөөцийн ашиглалт хамгаалалт

- Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх талаар гадаад орны төсөл хэрэгжүүлэх, энэ хүрээнд төв болон орон нутгийн авто замыг сайжруулах, үлийн цагаан оготнотой тэмцэх, заган ойг сэргээх, төв суурин газар мод, зүлэг тарих, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, мод үржүүлгийн газар байгуулах арга хэмжээ авах
- Байгалийн үзэсгэгэнт, ховор ан амьтан, ургамалтай газруудыг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авах

- Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийг хуваарьтай ашиглах, хаших, сайжруулах арга хэмжээ авах, бэлчээрийн даац малын тооны зохистой харьцааг бий болгох

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх "Газрын бүртгэл, кадастрын зураглалын тухай төсөл"-ийг бүх суманд хэрэгжүүлэх

- Говийн сумдын тодорхой газрыг байгалийн шинжлэл, аялал жуулчлал, ашигт малтмал олборлолт, ойжуулалт, нөхөн сэргээлтийн зориулалтаар гадаадын сонирхогч орон, хөрөнгө оруулагчдад урт хугацаагаар түрээсээр болон концессоор ашиглуулах асуудлыг судалж шийдвэрлэх

Байгаль орчныг хамгаалах

- Байгалийн нөөц ашигласны орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг олон түмний үйлс болгох, энэ талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, ТББ-аас гаргасан санаачлагыг бүх талаар дэмжих
- Байгаль орчны хяналтыг чангатгаж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах талаар хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах

Энэхүү хөгжлийн бодлогыг сумдын ард иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөс санал авч орон нутгийн ажилтнуудын хүчээр боловсруулж аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөр хэлэлцүүлэн баталсан тул амьдралд илүү ойр, хэрэгжих үндэслэл сайтай төдийгүй бодлогод тухай бүр нэмэлт өөрчлөлт хийж сайжруулж байх боломжтой учир энэ нь амьд баримт бичиг гэж үзэж байна.

2003 оны 7 дугаар сар Мандалговь хот